



МОНГОЛ УЛСЫН ТӨЛБӨРИЙН СИСТЕМ

ТОВХИМОЛ 2022

А Г У У Л Г А

Өмнөх үг	2
Нэр томъёоны товчлол	3
Нэг. Удиртгал	5
1.1. Төлбөрийн системийн хууль эрх зүйн орчин	7
1.2. Төлбөрийн систем дэх Төв банк (Монголбанк)-ны оролцоо	8
1.3. Төлбөрийн систем дэх хувийн хэвшлийн оролцоо	11
Хоёр.Төлбөрийн системийн тогтолцоо	14
2.1. Их дүнтэй төлбөрийн систем	14
2.2. Бага дүнтэй төлбөрийн систем	16
2.3. Төлбөрийн картын систем	18
Гурав. Бэлэн бус төлбөрийн хэрэгсэл	22
3.1. Төлбөрийн карт	23
3.2. Хөдөлгөөнт банк	25
3.3. Цахим мөнгө	27
Дөрөв.Төлбөрийн системийн хяналт шалгалт	30
4.1. Хяналт шалгалт	31
4.2. Үнэлгээ хийх	32
4.3. Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагааны зөвшөөрөл	37
Тав. Төлбөрийн системийг хөгжүүлэх дунд хугацааны стратеги	39

Өмнөх үг

Монголбанк төгрөгийн тогтвортой байдлыг хангах зорилтын хүрээнд үндэсний төлбөрийн системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах, үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үүрэгтэй ажилладаг. Тиймээс бид шинэ тутамд хөгжиж буй технологийн хөгжлийг нэвтрүүлэх, орчин үеийн дэвшилтэт системийн шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлэх, хууль эрх зүйн орчныг улам бүр боловсронгуй болгож, бэхжүүлэхийн төлөө зорин ажилладаг.

Төв банкнаас төлбөрийн системийн талаар баримтлах бодлогын баримт бичиг, стратегид цахим төлбөр тооцоо давамгайлсан, найдвартай, аюулгүй байдлыг хангасан төлбөрийн систем, үр ашигтай, хэрэглэгч төвтэй төлбөрийн үйлчилгээг бий болгохыг онцолж тусгасан билээ. Монгол Улс 2026 он гэхэд төлбөрийн системийн дэд бүтцийг сайжруулах, эрсдэлийг бууруулах, өрсөлдөөн, инновац, үйлчилгээний хүртээмжийг нэн тэргүүнд тавьсан, оролцогч байгууллагуудын дэмжлэгтэйгээр цахим төлбөр тооцоо давамгайлсан улс болох зорилгыг дэвшүүлсэн бөгөөд энэхүү зорилгын хүрээнд Төв банкнаас цахим төлбөрийн хэрэгсэл болон финтекийн хэрэглээг түгээн дэлгэрүүлэх, үр ашигтай, аюулгүй, нэгдмэл байдлыг хангах, хууль эрх зүйн орчныг сайжруулах, хэрэглэгчийн эрхийг хамгаалах замаар эдийн засгийн бүхий л оролцогч талууд түргэн шуурхай, аюулгүй, найдвартай төлбөрийн үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэхээр ажиллаж байна.

Монголбанкнаас төлбөрийн системд хяналт тавих чиг үүргийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, төлбөрийн системийн үйл ажиллагаа, бодлого зохицуулалт болон сүүлийн жилүүдэд гарсан өөрчлөлт, шинэчлэл, холбогдох тоон үзүүлэлтийг нэгтгэсэн энэхүү товхимлыг Та бүхний анхааралд толилуулж байна.

Энэхүү товхимлоос олон улсын стандартад нийцсэн, Монгол Улсын төлбөрийн системийн үйл ажиллагаа, техник, технологи, дэд бүтцийн талаар дэлгэрэнгүй үзэх боломжтой.

Товхимол нь ерөнхий танилцуулга, төлбөрийн систем, бэлэн бус төлбөр тооцоо, хяналт шалгалт ба дунд хугацааны стратеги гэсэн төлбөрийн системийн товч түүх, өнөөгийн байдал ба ирээдүйн зорилтыг тусгасан таван бүлгээс бүрдлээ. Цаашид Монголбанкнаас энэхүү товхимлыг тодорхой давтамжтайгаар бэлтгэж, нийтийн хүртээл болгохоор төлөвлөж байна.

МОНГОЛБАНКНЫ ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ

Г. ЭНХТАЙВАН

Нэр томъёоны товчлол

АСН+	Автомат клиринг хаус
ҮТСТХ	Үндэсний төлбөрийн системийн тухай хууль
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
ҮЦГТ	Үндэсний цахим гүйлгээний төв
ҮЦТХТ	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
ҮЦКТ	Үнэт цаасны клирингийн төв
RTP	Бодит цагийн гүйлгээний систем /Real Time Payment/
САМ	Дансны нэгдсэн сан /Central Address Module/
СЗЗДБ	Санхүүгийн зах зээлийн дэд бүтэц
ТБҮЦС	Төвбанкны үнэт цаасны систем
ТБҮЦ	Төвбанкны үнэт цаас
ҮЦТТС	Үнэт цаасны төлбөр тооцооны систем
ТэН	Төлбөрийн эсрэг нийлүүлэлт
ТэТ	Төлбөрийн эсрэг төлбөр
НУСЗЗГ	Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газар
ЦМХА	Цахим мөнгө хүлээн авагч

Монгол Улсын төлбөрийн системийн хөгжил



НЭГ. УДИРТГАЛ

Төлбөрийн систем нь санхүүгийн зах зээлийн чухал дэд бүтэц төдийгүй мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх гол суваг юм. Төлбөрийн системийн үндсэн зорилго нь банк, санхүүгийн салбарт хийгдэж буй төлбөр тооцоог тасралтгүй, найдвартай, шуурхай гүйцэтгэх замаар нийт эдийн засаг дахь мөнгөний эргэлтийг хурдасгах, ингэснээр санхүүгийн тогтвортой байдлыг хангах явдал юм.

Өндөр түвшний технологи нэвтрэхтэй зэрэгцэн зах зээлийн хөгжлийн хандлага, эрэлт шаардлагад нийцсэн бэлэн бус төлбөрийн шинэ дэвшилтэт хэрэгсэл хурдацтайгаар бий болж, төлбөр тооцоог түргэн шуурхай, үр ашигтай гүйцэтгэх боломж бүхий шинэ системийг нэвтрүүлэхэд хүргэж байна. Эдгээр системийн үр ашигтай, хэвийн ажиллагаа нь байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүн, бизнес эрхлэгчдэд санхүүгийн үүргээ биелүүлэх, мөнгөн хөрөнгөө аюулгүй, цаг тухайд нь шилжүүлэх боломжийг олгодог билээ.

Монгол Улсын төлбөрийн систем нь оролцогч хоорондын их дүнтэй гүйлгээний Банксүлжээ (RTGS), бага дүнтэй гүйлгээний ACH+, төлбөрийн картын систем гэсэн гурван системээс бүрддэг.

Төлбөрийн систем тус бүрийн оролцогчийн бүтэц, бүрэлдэхүүнийг Зураг 1-т банк, хуулийн этгээд, финтек байгууллагын нэрсээр жагсааж үзүүлэв.

Зураг 1



Эх сурвалж: Монголбанк

“Банксүлжээ” системээр 5 сая төгрөгөөс дээш дүнтэй гүйлгээ дамждаг бөгөөд тус систем нь гүйлгээг бодит цагийн горимоор дамжуулж байна. Их дүнтэй төлбөрийн систем нь нийт 20 оролцогч (Монголбанк, Сангийн яамны Төрийн сангийн газар, арилжааны 12 банк, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв, Хөгжлийн банк, Монголын үнэт цаасны клирингийн төв)-той юм.

АСН+ системээр 5 (таван) сая төгрөг, түүнээс доош дүнтэй гүйлгээ дамждаг бөгөөд тус систем нь гүйлгээг бодит цагийн горимд, 24/7 зарчмаар тасралтгүй дамжуулах, эсвэл багц болгож тодорхой давтамжийн дагуу дамжуулах сонголтыг оролцогч нарт олгодог. АСН+ систем нь оролцогч хооронд тухайн өдөрт хийгдсэн гүйлгээний өглөг ба авлагын дүнг харилцан суутгаж клиринг хийж, үр дүнгийн тооцоог тухайн ажлын өдөрт “Банксүлжээ” системд дамжуулах зарчмаар оролцогчдын дансанд тусгадаг. Бага дүнтэй төлбөрийн системд нийт 24 оролцогч (Монголбанк, Сангийн яамны Төрийн сангийн газар, банк, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв, Хөгжлийн банк, Монголын үнэт цаасны клирингийн төв болон финтек байгууллагууд) холбогдсон байна.

Төлбөрийн картын систем нь Монгол Улсад төлбөрийн үйлчилгээ эрхлэгч байгууллага хоорондын картын гүйлгээг дамжуулж, клиринг хийдэг бөгөөд, АСН+ системтэй адил

зарчмаар үр дүнг цэвэршүүлэн тооцож, дараагийн ажлын өдөр нь “Банксүлжээ” системд дамжуулж, оролцогчдын дансанд тусгадаг.

1.1. Төлбөрийн системийн хууль эрх зүйн орчин

Монгол Улсын төлбөрийн системийн эрх зүйн орчныг шинэчлэх ажлын хүрээнд “Үндэсний төлбөрийн системийн тухай” хууль 2017 оны тавдугаар сарын 31-ний өдөр батлагдаж, 2018 оны нэгдүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн нь Монгол Улсын үндэсний төлбөрийн системийг удирдах, зохион байгуулах, зохицуулах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахаас гадна Үндэсний төлбөрийн системд банкнаас бусад этгээд оролцох боломжийг нээсэн.

Хүснэгт 1

Төлбөрийн системийн эрх зүйн баримт бичгийн жагсаалт

Эрх зүйн баримт бичгийн нэр	Зохицуулалт	Хэрэгжиж эхэлсэн огноо
“Төв банк /Монголбанк /-ны тухай” хууль	Төв банк (Монголбанк)-ны бүрэн эрх, түүний удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, төрийн мөнгөний бодлогыг Төв банк (Монголбанк)-наас хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.	1996.10.01
“Үндэсний төлбөрийн системийн тухай” хууль	Монгол Улсын Үндэсний төлбөрийн системийг удирдах, зохион байгуулах, зохицуулах, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулна.	2018.01.01
Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх, систем ажиллуулах зөвшөөрөл олгох, зөвшөөрөлтэй этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих журам	Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 10.1 дэх хэсэгт заасан үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах хүсэлт гаргагчид тавих шаардлагыг тодорхойлох, хүсэлт гаргагч нь хууль тогтоомжид заасан шаардлага, нөхцөлийг хангасан эсэхийг судалж хянах, зөвшөөрөл олгох, татгалзах, зөвшөөрлийн нөхцөл, зөвшөөрөл эзэмшигчид тавих шаардлагыг тогтоох, олгосон зөвшөөрлийг сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулна.	2021.12.01
Их дүнтэй төлбөрийн системийн дүрэм	Их дүнтэй төлбөрийн системээр төлбөр тооцоо гүйцэтгэхтэй холбоотой хийгдэх үйл ажиллагаа, оролцогчийн эрх, үүргийг тодорхойлох, үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавих харилцааг зохицуулна.	2021.10.08
Автомат клиринг хаус системийн дүрэм	АСН+ системээр дамжуулан Монгол Улсын нутаг дэвсгэр дээр шилжүүлэг хийх, тус системд оролцох эрхийг олгох, түдгэлзүүлэх, оролцогчийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавих харилцааг зохицуулна.	2021.05.25

Төлбөрийн системийн хяналтын бодлого	Төлбөрийн системийн найдвартай үр ашигтай ажиллагааг хангуулах замаар үндэсний мөнгөн тэмдэгтэд итгэх олон нийтийн итгэл, санхүүгийн тогтвортой байдалд дэмжлэг үзүүлэх зорилготой.	2021.06.25
Төлбөрийн системийн тайлан гаргах заавар	Оролцогч, операторуудын сар, улирал бүр Монголбанканд ирүүлдэг төлбөрийн систем болон хөдөлгөөнт банкны тайлангийн загвар, бөглөх аргачлал, зааврыг багтаасан.	2020.01.01

Эх сурвалж: Монголбанк

1.2. Төлбөрийн систем дэх Төв банк (Монголбанк)-ны оролцоо

Төв банк (Монголбанк) нь төлбөрийн системийн үйл ажиллагаанд голлох үүрэг гүйцэтгэж, үндэсний төлбөрийн системийн бодлогыг тодорхойлж, нийт хэрэглэгчийн хэрэгцээг бүрэн хангасан, түргэн шуурхай, найдвартай, тасралтгүй ажиллагаатай төлбөрийн системийг хөгжүүлэх зорилт тавин ажиллаж байна.

“Үндэсний төлбөрийн системийн тухай” хуулийн зургаадугаар зүйлд: *“Монголбанк үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, зохицуулж, хяналт тавина”* гэж заасны дагуу Монголбанк дараах бүрэн эрхийг хэрэгжүүлдэг. Үүнд:

- Үндэсний төлбөрийн системийн бодлогыг тодорхойлох;
- Холбогдох зөвшөөрлийг олгох;
- Үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, төлбөрийн хэрэгсэл шинээр гаргах, төлбөрийн үйлчилгээ нэвтрүүлэхтэй холбогдсон дүрэм, журам батлах, шийдвэр гаргах;
- Зөвшөөрөл авсан этгээд, түүний төлбөрийн системд хамаарах үйл ажиллагаанд хяналт тавих;
- Төлбөрийн, клирингийн болон төлбөр тооцооны систем, төлбөрийн хэрэгсэл гаргахтай холбогдох бусад үйл ажиллагааг гүйцэтгэх.

Монголбанк нь төлбөрийн системийн найдвартай үйл ажиллагааг хангах, харилцагчдын эрх ашгийг хамгаалах үүднээс төлбөр тооцоонд шинээр нэвтэрч буй төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээг судлан, дүгнэлт гаргаж, системийн оролцогчдод холбогдох зөвшөөрлийг олгодог. Түүнчлэн төлбөр тооцоог бодит цагийн горимоор, тасралтгүй дамжуулж байгаа эсэх, холбогдох журам, гэрээг мөрдөж байгаа эсэх, өмнөх шалгалтаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангаж байгаа эсэхэд тогтмол хяналт тавин ажилладаг. Мөн Үндэсний төлбөрийн системийн зөвлөлийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах үүргийг гүйцэтгэж байна.

Монгол Улсын төлбөрийн системийн нийт оролцогчдын ашиг сонирхлыг нэгтгэх, хамтын ажиллагааг дэмжих замаар үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх зорилготойгоор Монголбанкны Ерөнхийлөгч, Монгол Улсын Сангийн сайд, СЗХ-ны даргын 2008 оны дөрөвдүгээр сарын 24-ний өдрийн хамтарсан тушаалаар Төлбөр тооцооны үндэсний зөвлөлийг байгуулсан билээ. Тус Зөвлөлийн үндсэн зорилт нь

Монгол Улсын төлбөрийн системийг боловсронгуй болгож, хөгжүүлэх, улмаар эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэхэд системийн оролцогчдын хамтын ажиллагааг бий болгон, өргөжүүлэх замаар санхүүгийн салбарын эрүүл, тогтвортой байдлыг дэмжих, системийн оролцогчдын эрх ашиг, сонирхол, үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, нэгтгэх, үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх стратегийг тодорхойлоход оршиж байсан юм.

ҮТСТХ батлагдсанаар тус Зөвлөлийг Үндэсний төлбөрийн системийн зөвлөл болгон шинэчилж, зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, дүрмийг Монголбанк батлахаар зохицуулсан байна. Зөвлөлийн гишүүдэд Монголбанк, арилжааны банк, Монголын банкны холбоо, Сангийн яамны Төрийн сангийн газар, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв, Арилжааны төлбөр тооцоо ХХК, Монголын хөрөнгийн бирж, СЗХ, Харилцаа холбооны зохицуулах хороо, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Монголын банк бус санхүүгийн байгууллагын холбоо, Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо болон цахим мөнгө гаргагч финтек байгууллагууд тус тус багтдаг.

Энэхүү зөвлөл нь үндэсний төлбөрийн системийн нэгдмэл байдлыг хангах, оролцогч хоорондын хамтын ажиллагааг дэмжих, төлбөрийн системийн хүрээнд мөрдөгдөж буй эрх зүйн баримт бичгийг олон улсын хэм хэмжээнд нийцүүлэх талаар зөвлөмж гаргах, төлбөрийн системийн хөгжил, үйл ажиллагаа, цаашдын чиг хандлага, нийгэмд үзүүлэх үр нөлөө болон эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбоотой мэдээлэл солилцох боломжийг системийн оролцогчдод олгож, зөвлөлийн дарга, гишүүдээс санал болгосон бусад асуудлыг хэлэлцэн шийдвэрлэдэг.

Олон улсын байгууллага ба хамтын ажиллагаа

Дэлхийн банк

Монголбанкнаас төлбөрийн системийн талаар Дэлхийн банктай 2002 оноос хамтран ажиллаж, банк хоорондын төлбөр тооцооны тайланг бэлтгэж эхэлсэн билээ. Банк хоорондын төлбөр тооцооны хэмжээ огцом нэмэгдэж эхэлсэнтэй холбоотойгоор Монголбанкны зүгээс олон улсын жишигт нийцсэн дэвшилтэт технологийг нэвтрүүлэхэд өндөр ач холбогдол өгч, төлбөрийн системийн дэд бүтцийг хөгжүүлэх зорилтын хүрээнд Дэлхийн банкны санхүүжилтээр “Санхүүгийн чадавхыг хөгжүүлэх” төслийг 2006 оноос хэрэгжүүлж эхэлсэн. Тус төслийн хүрээнд санхүүгийн дундын сүлжээг бий болгож, Төлбөр тооцооны төв (*одоогийн ҮЦГТ*)-ийг байгуулж, банк хоорондын төлбөр тооцоог их ба бага дүнтэй систем гэж ангилан, 1 сая төгрөгөөс доош дүнтэй гүйлгээг Төлбөр тооцооны төвөөр бодит цагийн горимоор дамжуулан, клиринг хийж, үр дүнгийн тооцоог банкуудын Монголбанкна дахь харилцах дансанд тусгадаг болсон.

Дэлхийн банкны хамтын ажиллагааг 2015 оноос дахин үргэлжлүүлж, үндэсний төлбөрийн системийн хөгжлийн чиг баримжааг тодорхойлох, хууль эрх зүйн орчныг сайжруулах зорилгоор техник туслалцааны хүрээнд ажиллаж байна. Энэ хүрээнд төлбөрийн системийг 2016-2021 онд хөгжүүлэх дунд хугацааны стратеги, Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн төслийг боловсруулахад хамтран ажиллалаа.

Хамтын ажиллагааны үр дүнд Монгол Улсын Үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх анхны стратегийн баримт бичгийг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр 2016 онд, “Үндэсний төлбөрийн системийн тухай” хуулийг Улсын Их Хурлаар 2017 онд тус тус батлуулснаар Монголбанкны төлбөрийн системийг хянан зохицуулах үүрэг, хариуцлагыг эрх зүйн хувьд баталгаажуулах, төлбөрийн системийн оролцогчдын хамтын ажиллагааг үр өгөөжтэй болгох нөхцөл бүрдсэн юм.

Азийн хөгжлийн банк (АХБ)

Монголбанк нь 2016 оноос эхлэн АХБ-тай хамтран “Төлбөрийн системийн шинэчлэл” төслийг хэрэгжүүлж, Монгол Улсын төлбөрийн системийн дэд бүтэц, програм хангамжийг шинэчлэх ажлыг үе шаттай зохион байгуулан ажиллаж байна. Төслийг хэрэгжүүлэх үндсэн зорилт нь Төв банкнаас зохицуулж, хянадаг, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад бүрэн нийцсэн, өрсөлдөхүйц, харилцан нягт уялдаа холбоотой, өндөр нууцлал бүхий төлбөрийн системийг бий болгох ажээ.

Энэхүү төслийг хэрэгжүүлснээр Монгол Улсыг бүхэлд нь хамарсан төлбөрийн цогц үйлчилгээ бүхий төлбөрийн системийн дэд бүтцийг бий болгож, системийн тасралтгүй, найдвартай байдлыг хангахад чухал ач холбогдолтой бөгөөд нийгэм, эдийн засагт дараах зэрэг үр дүн гарч, шинэчлэл хийгдэнэ. Үүнд:

- Төлбөрийн системийн уялдаа холбоог сайжруулж, хяналтыг нэмэгдүүлэх;
- Өндөр нууцлалтай, уян хатан цахим төлбөрийн системтэй болох;
- Технологийн дэвшлийг нэвтрүүлснээр нэгж гүйлгээнд ногдох шимтгэлийг бууруулах;
- Засгийн газар, Төв банкны бонд, үнэт цаасны нэгдсэн бүртгэлийн системийг сайжруулах;
- Цахим төлбөрийн системийг хөгжүүлж, бэлэн бус төлбөр тооцоог нийтийн хэрэглээ болгох;
- Бэлэн бус төлбөр тооцоог дэмжсэнээр далд эдийн засгийг бууруулж, татварын суурийг тэлэх;
- Үндэсний хэмжээнд төлбөр гүйцэтгэх боломж бүхий, цаг хугацаа болон бүс нутгийн байршлаас үл хамааран зах зээлийн оролцогч бүрд тохирсон төлбөрийн хэрэгслийг нэвтрүүлэх зэрэг болно.

Төслийг эхлүүлснээс хойш өнөөг хүртэл Монголбанкны болон ҮЦГТ-ийн дэд бүтэц, төлбөрийн системийн шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлээд байна. Үүнд:

- ҮЦГТ-ийн сүлжээний өргөтгөл, тоног төхөөрөмж, аюулгүй байдлын шинэчлэлийг хийсэн;
- “Банксүлжээ” систем (RTGS)-ийг шинэчилсэн;
- ҮЦГТ-ийн үндсэн болон нөөц дата төвүүдийг олон улсын стандарт (Tier II)-ын дагуу шинэчилсэн;
- Бага дүнтэй гүйлгээний ACH+–ийг шинээр нэвтрүүлж, багц болон дебит гүйлгээ хийх, дансны нэгдсэн санг ашиглах боломжийг бүрдүүлсэн;

- Үндэсний брэнд ₮ картын нууцлал, аюулгүй байдлыг хангах зорилгоор олон улсын EMV/NFC стандартад амжилттай шилжүүлсэн;
- ҮЦГТ-ийн оролцогч хоорондын картын системийг шинэчилсэн;
- Санхүүгийн байгууллага дундын цахим гарын үсгийг баталгаажуулах системийг нэвтрүүлсэн;
- Монголбанкны шинэ оффисын барилгын мэдээллийн технологийн дэд бүтцийн ажлыг санхүүжүүлсэн;
- Монголбанкны болон төлбөрийн системийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, халдлагаас хамгаалах систем (SOC)-ийг цогцоор нь нэвтрүүлсэн.

Цаашид төслийн үлдсэн хугацаанд шинэчлэлийн дараах ажлыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Үүнд:

- Монголбанкны бүртгэлийн системийг шинэчлэх;
- Үнэт цаасны нэгдсэн бүртгэл, хадгаламжийн системийг шинэчлэх;
- ҮЦГТ-д өндөр нууцлал бүхий карт болон мобайл гүйлгээг дэмжих систем (Tokenization system) нэвтрүүлэх;
- Монголбанкны их өгөгдөл хадгалах, боловсруулах системийг нэвтрүүлэх.

Мастеркарт

Монголбанк нь Мастеркарт байгууллагатай үндэсний брэнд ₮ картын EMV/NFC стандартыг боловсруулах, техникийн нөхцөлийг энгийн соронзон туузаас EMV/NFC чип технологид шилжүүлэх ажлын хүрээнд хамтран ажиллаж байна. Монголбанк нь Мастеркарт байгууллагатай “М чип” технологийн лиценз эзэмших эрх болон түншлэлийн гэрээг 2019 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр байгуулж, хамтын ажиллагааг албан ёсоор эхлүүлсэн юм. Монголбанк, Мастеркарт байгууллага, арилжааны банкууд хамтран EMV чип бүхий ₮ картын дебит болон кредит профайлыг боловсруулж, улмаар банкууд чиптэй ₮ карт гаргах, хүлээн авах техникийн нөхцөлийг хангаж, 2021 оны аравдугаар сараас арилжааны банкууд чиптэй ₮ картыг зах зээлд гаргаж эхэлсэн юм.

1.3. Төлбөрийн систем дэх хувийн хэвшлийн оролцоо

Төлбөрийн системийн оролцогч банкууд

Банкууд нь харилцах, хадгаламж төвлөрүүлэх, зээл, төлбөр тооцооны болон банкны бусад үйлчилгээг иргэд, хуулийн этгээдэд үзүүлэх үндсэн үүрэгтэй билээ. Монгол Улсад 2021 оны жилийн эцсийн байдлаар 11 банк 272 салбар, 1028 тооцооны төвтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс хөдөө орон нутагт 982 банкны нэгж, 845 тооцооны төв ажиллаж байна. Банк нь төлбөрийн системийн шууд оролцогч бөгөөд банкаар дамжин хийгдэж буй харилцагч аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн бэлэн болон бэлэн бус төлбөр тооцоог гүйцэтгэгч байгууллага юм.

Монголбанкнаас баталсан холбогдох журмын дагуу тусгай зөвшөөрөл авсан банк нь Банкны тухай хуулийн 2 дугаар бүлгийн 11 дүгээр зүйлд заасны дагуу төлбөр тооцооны дараах үйлчилгээг үзүүлдэг. Үүнд:

1. Өөрийн харилцагчид төлбөр тооцооны бүх төрлийн үйлчилгээг түүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр үзүүлэх;
2. Харилцагчийн даалгавраар харилцах дансны үлдэгдэлд багтааж мөнгөн хөрөнгийг шилжүүлэх гүйлгээ хийх;
3. Төлбөр тооцооны үйлчилгээний шимтгэлийг тогтоох;
4. Банк хоорондын төлбөр тооцоог Монголбанкна дахь харилцах дансаар дамжуулан хийх;
5. Банкны төлбөр тооцооны үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу эрхлэх.

Төлбөрийн системийн оролцогч финтек байгууллага

Монголбанкнаас төлбөрийн системийн найдвартай, тогтвортой, үр ашигтай ажиллагааг хангах, бэлэн бус төлбөрийн хэрэглээг дэмжих, санхүүгийн зах зээлийн дэд бүтцийг хөгжүүлэх бодлого баримталсны үр дүнд зах зээлд нэвтэрч буй шинэ төрлийн төлбөрийн үйлчилгээ, төлбөрийн хэрэгслийн тоо, тэдгээрийн чанар жилээс жилд хурдацтайгаар нэмэгдэж байна.


Дэвшилтэт технологийг ашиглан зөвхөн банк бус санхүүгийн байгууллага, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд энэ салбарт хүчтэй түрэн орж ирэн шинэ төлбөрийн үйлчилгээ, бүтээгдэхүүн, хэрэгслүүдийг зах зээлд амжилттай нэвтрүүлж байна.

Үндэсний төлбөрийн системийн тухай хууль хэрэгжиж эхэлснээр банк бус хуулийн этгээд Монгол Улсад цахим мөнгөний үйл ажиллагаа эрхлэх, төлбөрийн карт болон хөдөлгөөнт банкны процессор зэрэг төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх хууль эрх зүйн орчин бүрдсэн. Монголбанкнаас 2022 оны байдлаар Монголбанкнаас нийт долоон байгууллагад цахим мөнгө гаргах зөвшөөрөл, найман байгууллагад төлбөрийн картын процессор, хоёр байгууллагад хөдөлгөөнт банкны процессорын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл тус тус олгоод байна. Монголбанк эдгээр зөвшөөрөлтэй этгээдийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, газар дээрх шалгалтыг жилд нэгээс доошгүй удаа хийж, тасралтгүй, найдвартай үйл ажиллагааг хангуулж ажилладаг.

Төлбөрийн системийн оролцогч бусад байгууллага

Монгол Улсад төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлдэг санхүүгийн зуучлагч нь банкууд, Сангийн яамны Төрийн сангийн газар, ҮЦТХ, ҮЦКТ юм. Эдгээр санхүүгийн байгууллага нь ямар үйлчилгээ үзүүлж байгаа, ямар заавар журмын субъект болж байгаагаар хоорондоо ялгаатай байдаг.

Монгол Улсын төлбөрийн системээр мөнгөн хөрөнгө дамжуулах



Системийн оролцогч:


- Банк
- Төрийн сан
- Банкнаас бусад эрх бүхий хуулийн этгээд

ХОЁР. ТӨЛБӨРИЙН СИСТЕМ ИЙН ТОГТОЛЦОО

Төлбөрийн системээр 2018-2021 онд дамжсан гүйлгээний тоо, дүнг Зураг 2-оос харахад, 2018 оны нэгдүгээр улиралд гүйлгээний дүн 20 их наяд төгрөг байсан бол 2021 оны дөрөвдүгээр улиралд 147.6 их наяд төгрөгт хүрч, сүүлийн гурван жилийн хугацаанд долоо дахин, гүйлгээний тоо 9.3 саяаас 38.2 саяд хүрч дөрөв дахин өссөн зэрэг нь олон нийтийн зүгээс төлбөр тооцооны системийн түргэн шуурхай, амар хялбар үйлчилгээнд итгэх итгэл нэмэгдэж, бэлэн бус төлбөр тооцоог илүү сонгох болсонтой холбоотой юм.

Зураг 2

Төлбөрийн системийн оролцогч хоорондын 2018-2021 оны гүйлгээ / улирлаар/



Төлбөрийн системийн гүйлгээний дунджийг сүүлийн 2 жилийн байдлаар авч үзэхэд, картын гүйлгээний тоо 2020 оны байдлаар өдөрт 555 мянга байсан бол 2021 онд 827 мянгад хүрч, өмнөх оны мөн үеэс 49 хувиар, бага дүнтэй гүйлгээний өдрийн дундаж тоо 177 мянга байсан бол 2021 онд 268 мянгад хүрч, өмнөх онтой харьцуулахад 52 хувиар тус тус өссөн байна.


2.1. Их дүнтэй төлбөрийн систем

Монгол Улс “Банксүлжээ” системийг 2009 онд нэвтрүүлсэн. Анх тус системээр дамжих гүйлгээний доод хязгаар 1 сая төгрөг байсныг шинэчилж, 2018 онд 3 сая төгрөг, 2021 онд 5 сая төгрөг болгон нэмэгдүүлсэн бөгөөд тус систем нь гүйлгээг бодит цагийн горимоор дамжуулж байна. Их дүнтэй төлбөрийн систем нь нэн чухал систем учраас төв банк хариуцан ажиллуулж, үйл ажиллагааг нь удирдан зохион байгуулж байна. “Банксүлжээ” систем нь төлбөрийн системийн оролцогч хооронд хийгдэж буй их дүнтэй төлбөр тооцоог нэг бүрчлэн бодит цагийн горимоор Монголбанканд байршиж буй

банкны харилцах дансаар дамжуулан гүйцэтгэдэг. Түүнчлэн ҮЦГТ хариуцан ажиллуулж буй бага дүнтэй болон картын төлбөрийн системийн үр дүнгийн төлбөр тооцоог гүйцэтгэж байна.

Зураг 3

Банксүлжээ системээр 2018-2021 онд дамжсан гүйлгээний тоо ба дүн /улирлаар/



Эх сурвалж: Монголбанк


Зураг 3-аас үзэхэд 2018 оны дөрөвдүгээр улиралд гүйлгээний тоо огцом буурсан нь тус системээр дамжих нэгж гүйлгээний дүнгийн доод хязгаарыг нэмэгдүүлсэнтэй холбоотой юм. 2019-2021 онуудад гүйлгээний тоо өссөөр 2021 оны гуравдугаар улиралд 2018 оны дөрөвдүгээр улирлын үзүүлэлтээс давжээ. Гүйлгээний дүнгийн доод хязгаарыг 2021 оны 4 дүгээр улиралд дахин нэмэгдүүлсэн ч энэ нь Банксүлжээгээр дамжих гүйлгээний тоонд буурах нөлөө үзүүлээгүй юм. Гүйлгээний тоо 2018-2020 онд улирлын нөлөөллөөр өсөх ба буурах хандлагатай байсан бол 2021 онд дахин ажиглагдаагүй байна. Гүйлгээний дүнгийн хувьд 2018 оноос тогтмол өссөөр 18.8 их наяд төгрөгөөс 138.9 их наяд төгрөгт хүрч 7 дахин нэмэгджээ.

“Банксүлжээ” системийн шинэчлэлийг 2019 онд амжилттай нэвтрүүлсэн бөгөөд одоогоор хоёрдугаар үеийн хувилбараар ажиллаж байна. Энэхүү систем шинэчлэгдсэнээр оролцогч хоорондын их дүнтэй гүйлгээний төлбөр тооцоо (settlement)-ны эрсдэл буурч, системийн тасралтгүй ажиллагаа болон найдвартай байдал нэмэгдэж, гүйлгээг дамжуулах хурд, өдөрт дамжуулах гүйлгээний тоо, чадамж өмнөхөөс гурав дахин нэмэгдсэн зэрэг давуу тал бий болсон байна. Мөн системд дансны нэгдсэн дугаарлалтыг нэвтрүүлснээр олон улсын төлбөр тооцоо гүйцэтгэхэд илүү хялбар болох, оролцогч хоорондын төлбөр тооцоонд одоогийн ашиглаж байгаа дансны давхцал

арилах, банкны ажилтан дансны дугаарыг шивэх явцдаа тухайн данс зөв эсэхийг шалгах зэрэг боломжтой боллоо.

Зураг 4

Монгол Улсын ДНБ/Банксүлжээ системийн гүйлгээний харьцаа




Эх сурвалж: Монголбанк

Зураг 4-өөс үзэхэд, 2018 онд ДНБ-ний эргэц 2.5 байсан бол 2019 онд 7.8, 2020 онд 8.9, 2021 онд 11.3 болж нэмэгдсэн нь төлбөрийн системээр дамжуулах гүйлгээний өсөлтийг илэрхийлж буй бас нэгэн чухал үзүүлэлт юм.

2.2. Бага дүнтэй төлбөрийн систем

Бага дүнтэй төлбөрийн системийг анх 2006 онд нэвтрүүлсэн бөгөөд одоогийн байдлаар тус системээр 5 сая төгрөг хүртэлх дүнтэй гүйлгээг бодит цагийн горимоор, 24/7 зарчмаар дамжуулж байна. Бага дүнтэй төлбөрийн системийг Монголбанкны Төлбөр тооцооны газрын ҮЦГТ хариуцан ажиллуулдаг бөгөөд бүх банкны төвтэй өндөр хурдны шилэн кабель, мөн нөөц шугам болох физик кабелиар холбогдсон байдаг. Тус системд банкуудаас гадна финтек компаниуд холбогдож төлбөр тооцоогоо дамжуулж эхлээд байна.

Оролцогч хоорондын бага дүнтэй гүйлгээний систем (АСН+)-ийн ерөнхий бүтэц




Эх сурвалж: Монголбанк

Монголбанкнаас бага дүнтэй төлбөрийн системийн шинэчлэлийг хийж, 2019 онд олон улсын жишигт нийцсэн АСН+ системийг нэвтрүүлснээр бодит цагийн онлайн гүйлгээнээс гадна ижил зориулалт бүхий олон тооны гүйлгээг багцлан дамжуулах боломжийг бий болгосон байна. Мөн дансны нэгдсэн санг бий болгосноор хүлээн авагчийн нэр, данс зөрснөөс үүдэн банк хоорондын гүйлгээ амжилтгүй болох эрсдэл буурсан. Дансны нэгдсэн санд 2022 оны байдлаар бүх банкны хэрэглэгчийн дансны мэдээлэл бүртгэгдээд байна. АСН+ систем нь их хэмжээний гүйлгээг багц байдлаар нэгтгэн илгээх, хүлээн авагч банкинд зэрэг дамжуулах, тоон гарын үсгийг ашиглан гүйлгээний аюулгүй байдлыг хангах, үр дүнгийн төлбөр тооцоо хийх зорилгоор нөөц хөрөнгийг урьдчилан тусгаарлах, төлбөр тооцооны эрсдэлийг бууруулах, дансны нэгдсэн санд бүртгүүлсэн утасны дугаар, эсвэл цахим хаягийн тусламжтайгаар төлбөр тооцоог хялбар аргаар шуурхай хийх зэрэг боломжийг бүрдүүлсэн билээ.

Зураг 6

Бага дүнтэй төлбөрийн системийн оролцогч хооронд 2018-2021 онд дамжуулсан гүйлгээний тоо, дүн /улирлаар/



■ АСН+ системээр дамжсан гүйлгээний тоо /сая ширхэг/

■ АСН+ системээр дамжсан гүйлгээний дүн /их наяд/

Эх сурвалж: Монголбанк

Зураг 6-аас үзэхэд, бага дүнтэй гүйлгээний тоо, дүн тогтмол өссөн үзүүлэлттэй байгаа нь бэлэн бус төлбөр тооцоо иргэдийн өдөр тутмын төлбөр тооцоонд улам бүр өргөн хэрэглэгдэж байгааг харуулж байна.

2.3. Төлбөрийн картын систем

Төлбөрийн картын клирингийн системийг 2010 онд анх нэвтрүүлсэн нь карт эзэмшигч зөвхөн карт гаргасан банкны хүлээн авах төхөөрөмж (АТМ, ПОС г.м.) дээр гүйлгээ хийх боломжтой байсан хязгаарлагдмал байдлыг халж, Монгол Улсын хэмжээнд банк харгалзахгүйгээр төлбөрийн картаа ашиглах нэгдсэн сүлжээг бий болгосон ажээ.


Монголбанкны хариуцан ажиллуулж буй төлбөрийн картын систем нь үндсэн болон дэд гишүүн оролцогчийн төлбөр тооцоог бодит цагийн горимоор 24/7 зарчмаар тасралтгүй дамжуулдаг.

Картын системийг 2021 онд бүрэн шинэчилж, нууцлал, аюулгүй байдал, олон улсын стандартыг хангасан шинэ програм хангамжийг нэвтрүүлсэн нь гүйлгээ боловсруулах хурд, хүчин чадал нэмэгдэх, төлбөрийн картын шинэ төрлийн гүйлгээг боловсруулах зэрэг давуу тал бий болжээ. Систем нэвтэрснээр оролцогчид үр дүнгийн төлбөр тооцоо хийх зориулалттай нөөц хөрөнгийг урьдчилан тооцоолж, дансанд тусгаарлан

байршуулах, удирдах, маргаантай болон алдаатай гүйлгээг илрүүлсэн агшинд харилцан тохиролцож, холбогдох залруулгын гүйлгээг өөр хоорондоо үүсгэн шийдвэрлэх боломжтой боллоо. Ойрын хугацаанд биет бус төлбөрийн картын мэдээллийг ашиглан гар утсаар төлбөр тооцоо хийх боломжийг олгох токенжуулах (Token service provider) ажлыг нэвтрүүлэхээр ажиллаж байна.

Зураг 7

Монгол Улсын төлбөрийн картын системийн бүтэц




Эх сурвалж: Монголбанк

Зураг 7-д дүрсэлсэн картын системийн схемээс үзэхэд ҮЦГТ-ийн хариуцан ажиллуулж буй картын системд оролцогч 7 байгууллага (Хасбанк, ХААНБ, Төрийн банк, Голомт банк, Чингэсхаан банк, Хай пэй солюшн ХХБ болон Худалдаа хөгжлийн банк) шууд холбогдсон байдаг. ҮЦГТ-ийн системд холболт хийгдээгүй 5 байгууллага (Богд банк, Капитрон банк, Үндэсний хөрөнгө оруулалтын банк, Ариг банк, Тээвэр хөгжлийн банк) нь Худалдаа хөгжлийн банкны картын системээр дамжуулан системийн оролцогч хоорондын картын төлбөр тооцоог илгээж, хүлээн авдаг.

Зураг 8

Картын системээр 2018-2021 онд дамжсан гүйлгээний тоо, дүн /улирлаар/



■ ҮЦГТ-н картын системээр дамжсан гүйлгээний тоо /мянган ширхэг/


■ ҮЦГТ-н картын системээр дамжсан гүйлгээний дүн /тэрбум төгрөг/

Эх сурвалж: Монголбанк

Картын системээр 2018-2021 онд дамжуулсан нийт гйлгээний тоо, дүнг Зураг 8-аас үзэхэд 2018 оны нэгдүгээр улирлаас 2021 оны дөрөвдүгээр улирлын хугацаанд гүйлгээний тоо жилийн дундуур өсөлт ба бууралттай буюу улирлын хамааралтай байдаг ч жил тутам өссөн үзүүлэлттэй байна. Харин гүйлгээний дүн 2019, 2020 оны дөрөвдүгээр улиралд бууралттай, бусад улиралд өсөлттэй байжээ.

Бэлэн бус төлбөр тооцоо

Төлбөрийн карт /сая ширхэг/:



Төхөөрөмжийн эзлэх хувь /2021/:



Хөдөлгөөнт банк



Цахим мөнгө

ГУРАВ. БЭЛЭН БУС ТӨЛБӨРИЙН ХЭРЭГСЭЛ

Монгол Улсад төлбөр тооцоонд бэлэн мөнгөнөөс гадна дараах төрлийн төлбөрийн хэрэгсэл, сувгийг ашиглаж байна. Үүнд:


- Төлбөрийн карт;
- Интернет банк;
- Мобайл банк;
- Цахим мөнгө;
- Төлбөрийн даалгавар, нэхэмжлэл буюу кредит шилжүүлэг;
- Биллинг;
- Мөнгөн гуйвуулга зэрэг багтана.

Банк, санхүүгийн үйлчилгээ авах арга зам эрс өөрчлөгдөж байна. Иргэд банканд очиж дугаарлах бус, интернет, мобайл банк ашиглах, бараа үйлчилгээний төлбөрөө бэлэн мөнгөөр бус карт, QR код, цахим хэтэвч ашиглан төлөхийг эрмэлздэг болж байна. Дэвшилтэт технологийг ийнхүү ашигласнаар санхүүгийн байгууллагууд илүү ухаалаг шийдвэр гаргах, хүн тус бүрд тохирох санхүүгийн үйлчилгээг санал болгох, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, банк санхүүгийн байгууллагад очин дугаарладаг явдлыг багасгах давуу тал бий болно.

Бэлэн мөнгө нь төлбөрийн гол хэрэгсэл байсаар байгаа хэдий ч иргэдийн дунд өдөр тутмын төлбөр тооцоондоо төлбөрийн карт, мобайл банк, интернет банк болон кредит шилжүүлгийг ашиглах нь илүү амар хялбар, түргэн шуурхай гэж үзэж байгаа тул бэлэн бус төлбөрийн хэрэгслийн хэрэглээ жил тутамд өсөн нэмэгдсээр байна.

Зураг 9

Төлбөрийн картын бэлэн ба бэлэн бус гүйлгээний
2017-2021 оны тоо (хувиар)



Эх сурвалж: Монголбанк

Түүнчлэн Ковид-19 цар тахал, технологийн дэвшил болон эдийн засгийн бусад нөлөөллөөс шалтгаалж бэлэн бус төлбөр тооцооны хэрэглээ дэлхий даяар өсч байна.

Зураг 9-өөс үзэхэд, төлбөрийн картын бэлэн бус гүйлгээний тоо 2017 оноос тогтмол өссөөр 2021 онд нийт гүйлгээний 88.2 хувийг, харин бэлэн гүйлгээний тоо байнга буурсаар 2021 онд 11.8 хувийг эзэлж, төлбөрийн картыг бэлэн бус төлбөр тооцоонд ашиглах хэрэглээ нэмэгдэж, бэлэн мөнгөжүүлэх хандлага буурчээ.

3.1. Төлбөрийн карт

Монголбанкнаас бэлэн бус төлбөр тооцоог хөгжүүлэх бодлогыг баримталж, төлбөрийн дэвшилтэт шинэ хэрэгслийг нэвтрүүлэхэд банк болон банк бус санхүүгийн финтек байгууллагыг дэмжиж ажилладаг. Монголбанкнаас санаачлан банкуудтай хамтран ажилласны үр дүнд үндэсний брэнд ₮ картыг зах зээлд гаргасан цагаас хойш картын зах зээлийн дийлэнх хувийг ₮ картын гүйлгээ эзлэх болсон билээ. Өнөөдрийн байдлаар банкууд ₮ карт, Виза, Мастеркарт, Юнионпэй, Американ экспресс болон Жэй Си Би гэсэн зургаан төрлийн төлбөрийн картыг өөрийн оноосон нэрээр гаргаж байна. Өнгөрсөн 2021 оны байдлаар нийт картын 60 орчим хувийг үндэсний брэнд ₮ карт дангаар эзэлж, зах зээлд тэргүүлж байгаа бол Юнионпэй карт 23 хувь, Виза карт 15 орчим хувийг эзэлж зах зээлд түлхүү ашиглагдаж байна.

Зураг 10

Төлбөрийн картын төрөл, зах зээлд эзлэх хувь, гүйлгээний тоо, дүн


Картын төрөл	2020			2021		
	зах зээлд эзлэх хувь	гүйлгээний тоо (мянган ширхэг)	гүйлгээний дүн (тэрбум төгрөг)	зах зээлд эзлэх хувь	гүйлгээний тоо (мянган ширхэг)	гүйлгээний дүн (тэрбум төгрөг)
 ₮ карт	63.6%	318,976.07	20,983.67	58.5% ↓	333,965.87 ↑	21,529.91 ↑
 Виза	12.7%	65,358.17	7,646.13	14.9% ↑	91,212.28 ↑	9,879.36 ↑
 Мастеркарт	3.0%	4,500.64	273.37	3.4% ↑	7,851.18 ↑	472.51 ↑
 ЮнионПэй	20.3%	111,128.89	8,242.69	23.0% ↑	150,198.51 ↑	11,033.70 ↑
 Амекс	0.1%	177.52	49.48	0.1% ●	162.53 ↓	72.92 ↑
 ЖэйСиБи	0.2%	328.63	14.92	0.2% ●	256.37 ↓	12.56 ↓

Эх сурвалж: Монголбанк

Үндэсний брэнд ₮ картыг EMV/NFC чип технологид шилжүүлэх, мөн оролцогч хоорондын бага дүнтэй болон картын системийн нууцлал, аюулгүй байдлыг хянах, удирдах шинэ системийг нэвтрүүлэх ажлыг 2021 онд амжилттай хийж гүйцэтгэлээ. EMV чипийг ₮ картанд ашиглаж эхэлснээр картын мэдээллийг хуулбарлан хуурамч карт хэвлэх, хулгай залилангийн гүйлгээ хийх эрсдэл буурч, үндэсний брэнд ₮ картын

нууцлал, аюулгүй байдлыг олон улсын түвшинд хүргэсэн юм. Харилцагчид EMV/NFC технологийн тусламжтай картыг зайнаас уншуулах, нийтийн тээвэрт төлбөрийн картаа ашиглах, ПИН кодгүй гүйлгээ хийх, гар утсанд суурилсан төлбөрийн картын үйлчилгээ болон бусад финтекийн шинэ дэвшилтэт үйлчилгээг авах боломж нээгдэж, төлбөр тооцоо хийхэд илүү хялбар, хурдан болох давуу тал бий болоод байна. Мөн олон улсын ISO/IEC 7816-5 буюу “Нэгдсэн хэлхээний картын стандарт”-ыг үндэсний стандартаар батлуулсан бөгөөд ₮ картын чипэнд харилцагчийн хувийн болон санхүүгийн мэдээллийг оруулах, өөрийн орны төлбөрийн системийн онцлогт тохирсон аппликейшныг боловсруулж, ашиглах боломж бий болж байна. Түүнчлэн, төлбөрийн картын хэрэглээ нэмэгдэж байгаа нь картын төхөөрөмжийн тоог нэмэгдүүлэх шаардлагыг бий болгосон ажээ.

Зураг 11.




Зургаас үзэхэд, төхөөрөмжийн тоо сүүлийн гурван жилийн хугацаанд өсөн нэмэгдсэнээс ПОС төхөөрөмж дийлэнх хувийг эзэлж байна.

Эх сурвалж: Монголбанк

Санхүүгийн хүртээмжийг сайжруулахад картын төхөөрөмжийн тоог нэмэгдүүлэх нь бас нэгэн чухал дэмжлэг болдог. Энэхүү өөрчлөлтийг 1000 хүн тутамд ногдох төхөөрөмжийн тооны өсөлтөөс харж болох бөгөөд 2019 онд 1000 хүн 39 төхөөрөмж ногдож байсан бол 2021 онд 51 төхөөрөмж болж нэмэгджээ.

Зураг 12.



Эх сурвалж: Монголбанк

Бэлэн бус төлбөр тооцооны үйлчилгээг өргөжүүлэх зорилгын хүрээнд 2016 онд банк хоорондын цахим худалдааны үйлчилгээг нэвтрүүлсэн юм.


Цахим худалдааны сүүлийн хоёр жилийн үзүүлэлтээс үзэхэд, цахим худалдаа хийх тохиолдол огцом өсч, 2020 оны эхэнд 327.5 мянга байсан гүйлгээнтэй тоо 2021 оны жилийн эцэст 1.4 саяд хүрч дөрөв дахин нэмэгдсэн нь төлбөрийн үйлчилгээг амар хялбар болгож, цаг хугацааг хэмнэсэн төлбөрийн шинэлэг гарц болж байгааг харуулж байна.

3.2. Хөдөлгөөнт банк

Монгол Улсад 11 банк хөдөлгөөнт банкны үйлчилгээг үзүүлж байна. Хөдөлгөөнт банкны үйлчилгээнд интернет банк, мобайл банк болон телефон банкны үйлчилгээ хамрагдана.

Зураг 13

Хөдөлгөөнт банкны нийт гүйлгээний дүнд эзлэх хувь



Эх сурвалж: Монголбанк

Хөдөлгөөнт банкны нийт гүйлгээний хамгийн их буюу 65.8 хувийг банк хоорондын гүйлгээ, 22.4 хувийг банк доторх гүйлгээ, 5.2 хувийг хөдөлгөөнт банкны процессороор дамжуулсан гүйлгээ, 3.3 хувийг олон улсын гүйлгээ эзэлж байна.

Үүнээс үзэхэд хөдөлгөөнт банкны үйлчилгээ нь төлбөрийн системийн хүртээмжийг нийтэд хүргэх гол суваг болоод байна. Төлбөр хийх, зээл төлөх зэрэг бусад төрлүүд хөдөлгөөнт банкны гүйлгээнд 0.03-аас 1.7 хувийг эзэлж байгаа нь харилцагчид хөдөлгөөнт банкны үйлчилгээг шилжүүлэг хийхэд түлхүү ашигладгийг харуулж байна

Интернет банк

Хөдөлгөөнт банкны хэрэглэгчийн графикийг (хуудас 22) үзэхэд, Монгол Улсын хэмжээнд 2021 оны байдлаар нийт 3.2 сая интернэт хандалтын эрхтэй хэрэглэгч байгаа бөгөөд эдгээрийн 74.6 хувийг хот суурин газар, үлдсэн 25.4 хувийг орон нутгийн хэрэглэгчид эзэлж байна.

Мобайл банк

Манай улсын хэмжээнд 2021 оны байдлаар 1.8 сая мобайл хандалтын эрхтэй хэрэглэгч бүртгэгдсэн (хуудас 22) нь өмнөх оны үзүүлэлтээс 32.7 хувиар өссөн байна. Мобайл

хандалтын эрх бүхий хэрэглэгчдийг хот, аймаг тус бүрээр авч үзвэл 56.7 хувийг хот суурин газар, үлдсэн 43.3 хувийг орон нутгийн хэрэглэгчид эзэлж байна. Мобайл банкны үйлчилгээ нь алслагдсан газар, орон нутагт оршин суугаа иргэдэд банкны үйлчилгээг хүргэх гол суваг болдог.

Сүүлийн жилд Монголбанкнаас хэрэгжүүлж буй томоохон нэг төсөл бол Мобайл төлбөр тооцооны токен систем нэвтрүүлэх ажил юм. Тус системийг нэвтрүүлснээр картын мэдээллийг гар утсандаа бүртгүүлж, мобайл хэтэвч байдлаар ашиглан, зайнаас төлбөр тооцоог хурдан шуурхай, аюулгүй гүйцэтгэх, картын мэдээлэл алдагдах болон залилан, луйврын гүйлгээний эрсдэл буурах юм. Түүнчлэн банк, санхүүгийн байгууллагууд гар утсаар гүйлгээ хийх болон токен үйлчилгээний нэгдсэн системийн үйлчилгээг авч, дэд бүтцийн хөрөнгө оруулалтын давхардсан зардлыг хэмнэх боломжтой. Одоогийн байдлаар систем нийлүүлэгч байгууллагатай хамтран ажиллах гэрээг байгуулан нэвтрүүлэлтийн ажлыг эхлүүлээд байна.

Телефон банк

Телефон банк гэж хэрэглэгч тусгай дугаарт холбогдон төлбөр тооцоотой холбоотой гүйлгээг хийх боломжийг олгож байгаа хөдөлгөөнт банкны үйлчилгээ юм. 2021 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд нийт 609.8 мянган телефон банкны эрхтэй хэрэглэгч байгаа нь (хуудас 22) өмнөх оныхоос 216.9 мянга буюу 55.2 хувиар өссөн байна. Телефон банкны эрх бүхий хэрэглэгчдийн 53.6 хувийг хот суурин газрын, үлдсэн 46.4 хувийг орон нутгийн оршин суугчид эзэлж байна. Телефон банкны үйлчилгээг хоёр банк үзүүлж байгаа боловч нийт хэрэглэгчийн 97.4 хувь буюу 594.2 мянга нь Төрийн банкны хэрэглэгчид байна.

Зураг 14

Хөдөлгөөнт банкны гүйлгээний тоо
(2020-2021 он, мянгаар)




Эх сурвалж: Монголбанк

Хөдөлгөөнт банкны гүйлгээний тоог хандалтын сувгаар нь авч үзэхэд цахим хуудас, мобайл хандалт, телефон банкны үйлчилгээ харьцангуй тогтмол түвшинд байгаа бол гар утасны хандалт жил тутам нэмэгдсээр байна. Тухайлбал, гар утасны аппликейшнаар хийсэн гүйлгээний тоо ширхэг 2020 оны эхэнд 50 орчим сая ширхэг байсан бол 2021 оны эцэст 120 сая ширхэг болж 2 дахин нэмэгдэж, хамгийн их өөрчлөлтийг үзүүлжээ.

Цахим хуудсаар хандах хандалт харьцангуй нэмэгдсэн боловч бусад сувагтай харьцуулахад хамгийн бага хандалттай байна.

Зураг 15

Интернет хандалтын гүйлгээнд эзлэх хувь
(2021 он, хувиар)



Эх сурвалж: Монголбанк

Хөдөлгөөнт банкны гүйлгээний интернет хандалтын байдлыг авч үзэхэд, гар утасны аппликейшнээр 89 хувь, цахим хуудсаар 11 хувь нь хандаж байгаа нь Монгол орон шиг алслагдсан нутаг дэвсгэртэй улсад гар утасны аппликейшин нь төлбөрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, хурдан шуурхай үйлчилгээг амар, хялбар авах гол суваг болсон байгааг харуулж байна.

3.3. Цахим мөнгө

Дэвшилтэт технологийг ашиглан зөвхөн банк төдийгүй банк бус санхүүгийн байгууллага, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд шинэ төлбөрийн үйлчилгээ, бүтээгдэхүүн, хэрэгслийг зах зээлд амжилттай нэвтрүүлж байна. “Үндэсний төлбөрийн системийн тухай” хуульд Монголбанкнаас цахим мөнгөний үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг олгохоор зохицуулсан бөгөөд өнөөдрийн байдлаар нийт 7 финтек байгууллага цахим мөнгөний үйлчилгээ үзүүлж байна.

Дээрх хуульд: “Цахим мөнгө дараах шинжийг нэгэн зэрэг агуулсан байна” гэж заасан. Үүнд: Мөнгөн дүн нь цахим хэлбэрээр хадгалагдсан, мөнгөн хөрөнгөөр баталгаажсан, цахим мөнгө гаргагч, түүний харилцагчаас бусад гуравдагч этгээд төлбөрт хүлээн зөвшөөрсөн, цахим мөнгө нь мөнгөн хөрөнгөнд, мөнгөн хөрөнгө нь цахим мөнгөнд чөлөөтэй хөрвөх зэрэг хамаарна. Цахим мөнгөний журмын 8.1-т: “Үйлчилгээ эрхлэгч нь өөрийн гаргасан цахим мөнгөтэй тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг баталгаа болгон 100 (нэг зуун) хувь “Баталгааны дансанд” байршуулна” гэж зохицуулсан байдаг.

Монголбанкнаас цахим мөнгө гаргах зөвшөөрөл авсан хуулийн этгээдийн гаргасан цахим мөнгө 2019 онд 4.4 тэрбум төгрөг байсан бол 2020 онд 7.6 тэрбум, 2021 онд 11.5 тэрбум төгрөг болж гурав дахин нэмэгдээд байна.

Өндөр хурдтайгаар хувьсан шинэчлэгдэж байгаа технологийн эрин зуунд төлбөрийн үйлчилгээний энэхүү шинэ төрлийг дэмжих, үйлчилгээний боломжийг нэмэгдүүлэх, шинэлэг эко шийдэл бүхий үйлчилгээг нэвтрүүлэх сонирхолтой финтек байгууллагууд цаашид нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд шинээр цахим мөнгө гаргах хүсэлтэй байгууллагууд Монголбанканд хандсаар байна.

Зураг 16

Цахим мөнгөний хэмжээ
(2019-2021 он, тэрбум төгрөг)




Монголбанкнаас санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, төлбөрийн үйлчилгээний зардлыг бууруулах, амар хялбар, шуурхай хэлбэрээр нийтэд үзүүлэх дэвшилтэт шийдлийг дэмжихэд байнга нээлттэй байх бодлогыг баримталж байна.

Эх сурвалж: Монголбанк

Зураг 17
Цахим мөнгөний хэрэглэгч (мянга)

Цахим мөнгөний хэрэглээ нэмэгдэж байгааг бүртгэлтэй болон бүртгэлгүй хэрэглэгчийн тооны өсөлтөөс харж болно. Бүртгэлтэй хэрэглэгч 2020 онд 958.7 мянга байсан бол 2021 онд 1.3 сая хэрэглэгч болж нэмэгдсэн байна. Үүний адилаар бүртгэлгүй хэрэглэгч /давхардсан байдлаар/ 2020 онд 3.6-с 2021 онд 4 саяд хүрчээ. Гэвч идэвхтэй хэрэглэгч, төлөөлөгч, ЦМХА-ийн хэрэглэгчийн тоо буурсан үзүүлэлттэй байгааг Зураг 17-д үзүүлэв.



Эх сурвалж: Монголбанк

Төлбөрийн системийн хяналт



- **Хяналт шалгалт**
- **СЗЗДБЗ-ийн хэрэгжилт ба үнэлгээ**
- **Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагааны зөвшөөрөл**

ДӨРӨВ. ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ

Монголбанкнаас төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, төлбөрийн хэрэгсэл гаргагч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагааг эрхлэх эрх бүхий этгээд болон операторын зохистой засаглал, удирдлага, үйл ажиллагаа, хэрэглэгчтэй холбогдох харилцаа, систем хоорондын хамаарлыг зохицуулсан журам, дүрэм, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавин ажилладаг. Ийнхүү хяналт тавих нь системийн эрсдэлийг хязгаарлан, хэрэглэгчийн болон эдийн засгийн хэрэгцээг хангаж, найдвартай, үр ашигтай ажиллаж байгааг баталгаажуулах зорилготой юм.

Хяналт нь урьдчилж тогтоосон стандарт болон хяналтын бодлогод заасан шаардлагын дагуу төлбөрийн системийг үнэлэхээс гадна эдийн засаг дахь төлбөр тооцоог гүйцэтгэх зохицуулалтыг бүхэлд нь бэхжүүлэхэд чиглэсэн өргөн үйл ажиллагааг хамардаг.

Олон улсын төлбөр тооцооны банк болон Үнэт цаасны хорооноос гаргасан, олон улсад нийтлэг мөрдөж буй зарчмуудад Төв банк нь хяналтын зорилгод нийцсэн эрх, үүрэгтэй байх, хариуцлагын тогтолцоог хэрэгжүүлэх хууль ёсны онцгой эрх, хүчин чадалтай байхыг шаарддаг тул Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд Монголбанк нь үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, зохицуулах, хяналт тавихаар заасан байна.

Мөн Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд Монголбанк нь төлбөрийн системийг бүхэлд нь болон бүрэлдэхүүн хэсгийг зохицуулах, хянах талаар тусгаж, төлбөрийн системд хяналт тавих үүргийг Монголбанканд хүлээлгэжээ. Монголбанкнаас “Төлбөрийн системийн хяналтын бодлого”-д хяналт шалгалтад баримтлах зарчмыг тодорхойлсон байдаг бөгөөд төлбөрийн системийн хянан шалгагч нар холбогдох хууль тогтоомж болон “Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх, систем ажиллуулах зөвшөөрөл олгох, зөвшөөрөлтэй этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих журам”-д заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдээр хангуулахад анхаарч төлбөрийн системийн хяналтыг хэрэгжүүлж байна.

Төлбөрийн системийн хяналтын зарчмууд

Төв банкны төлбөрийн системийн хяналтын чиг үүрэг нь Олон улсын төлбөр тооцооны банкны Төлбөрийн болон зах зээлийн дэд бүтцийн хорооноос боловсруулан гаргасан олон улсад нийтлэг мөрдөх зарчмуудад тулгуурладаг. Түүнчлэн тус хорооноос гаргасан “Төв банкны хяналтын тайлан”-д заасан хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх дараах үндсэн таван зарчмыг баримтлан ажилладаг. Тухайлбал:

1. Төв банк нь өөрийн хяналтын бодлогыг олон нийтэд мэдээлж, систем бүрд хамаарах шаардлага ба шалгуур үзүүлэлтийг тогтоодог.
2. Төв банкнаас төлбөрийн системүүдэд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн холбогдох стандартыг мөрдүүлж ажилладаг.
3. Төв банк нь хяналтын үүрэг хариуцлагаа үр дүнтэй хэрэгжүүлэх бүрэн эрх, чадавхтай байх зарчмын хүрээнд хууль тогтоомжийг тодорхойлж, мэдлэг, туршлагатай хянан шалгагч нарын багийг бүрдүүлсэн.
4. Төв банкны ажиллуулдаг систем, бусад төлбөрийн системүүдэд хяналтын стандартуудыг тогтмол мөрдүүлж ажилладаг.

5. Төлбөрийн системүүдийн аюулгүй, үр ашигтай байдлыг дэмжихийн тулд төв банк нь бусад орны төв банк болон эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах зарчмыг тус тус баримталдаг.

4.1. Хяналт шалгалт

Монголбанкнаас төлбөрийн системийн оператор болон оролцогчийн эрх зүйн баримт, мэдээлэл, статистик үзүүлэлтийг тогтмол, тодорхой давтамжтайгаар цуглуулж, дүрэм, журамд нийцэж байгаа эсэхэд газар дээр болон зайнаас хяналт тавин ажилладаг. Үүнд:

- Төв банкны хариуцан ажиллуулдаг төлбөрийн системийн операторын үйл ажиллагаанд хийх шалгалт (*их дүнтэй төлбөрийн систем буюу Банксүлжээ систем, ҮЦГТ-ийн бага дүнтэй төлбөрийн систем*);
- Төлбөрийн системийн оролцогчийн үйл ажиллагаанд хийх шалгалт (*банкуудын иж бүрэн шалгалт*);
- Төлбөрийн картын процессорын үйл ажиллагаа эрхлэгч байгууллагуудад хийх шалгалт;
- Цахим мөнгөний үйл ажиллагааны иж бүрэн шалгалт.

Монгол Улсад цар тахал бүртгэгдсэн нөхцөл байдалтай уялдуулан зарим шалгалтыг 2021 онд анх удаа зайнаас хийлээ. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүрд мэдэгдэж, залруулах талаар хянан шалгагч нар өөрийн бүрэн эрхийн хүрээнд хугацаатай үүрэг даалгавар өгч, зарим байгууллагад Улсын байцаагчийн мэдэгдэл, актыг хүргүүлж ажилладаг.

Системийн тасралтгүй үйл ажиллагааны тухай

Монголбанк нь төлбөрийн системийн оператор болон оролцогчийн системийн тасралтгүй найдвартай ажиллагаанд зайнаас тогтмол хяналт тавьж, сар бүр тасралтгүй ажиллагааны тайланг нэгтгэн гаргадаг. Системийн оролцогч нь төлөвлөгөөт бус гэнэтийн тасралт үүсгэсэн бол учир шалтгааныг тогтоох, холбогдох арга хэмжээг авч эргэн тайлагнах шаардлагыг Төв банкнаас тавьдаг. Тасралтгүй ажиллагааг хангаагүй оролцогчийн бүртгэлийг хянаж ажилладаг.

Зайнаас тавих хяналтаас гадна төлбөрийн системийн оролцогчдыг хамруулсан газар дээрх иж бүрэн шалгалтыг жил бүр дараах байдлаар хийж гүйцэтгэдэг. Үүнд:

- Төв банкны хариуцан ажиллуулдаг төлбөрийн системийн операторын үйл ажиллагааны шалгалт (*“Банк сүлжээ” систем, ҮЦГТ-ийн бага болон картын клирингийн систем*);
- Бусад төлбөрийн системийн операторын үйл ажиллагааны шалгалт;
- Төлбөрийн системийн оролцогч банкуудын иж бүрэн шалгалт;
- Төлбөрийн системийн тайлантай холбоотой банкны шалгалт;
- Цахим мөнгөний үйл ажиллагааны иж бүрэн шалгалт.

Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүрд мэдэгдэж, залруулах талаар хянан шалгагч нар арга хэмжээ авч ажиллах бүрэн эрхийг Төвбанк (Монголбанк)-ны тухай, Үндэсний төлбөрийн системийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомжоор хангасан байдаг.

Тоон мэдээлэл боловсруулах

Монголбанкнаас төлбөрийн хэрэгслийн хэрэглээний статистик үзүүлэлтийг тодорхой давтамжтайгаар нэгтгэж, боловсруулан тайлагнаж ажилладаг. Тухайлбал, төлбөрийн

системийн болон хөдөлгөөнт банкны тайланг бэлтгэн Монголбанкны цахим хуудсанд байршуулж, төлбөрийн системийн оролцогчид, олон нийтийг мэдээллээр хангадаг. Монголбанкны тайланг хэвлэл мэдээллийн байгууллага, төлбөрийн системийн оролцогчид, судалгаа шинжилгээний байгууллага, сонирхогч этгээд зэрэг байгууллагууд ашиглаж байна.

4.2. Үнэлгээ хийх

Монголбанк ОУТТБ-аас гаргасан СЗЗДБ-ийн 24 зарчим, таван үүрэг хариуцлагатай нийцүүлэн хийх “Үнэлгээний аргачлал”-ыг баталж гаргасан бөгөөд үүний дагуу жил бүр системийн хувьд нэн чухал болох Банксүлжээ систем болон ТБҮЦС үнэлгээ хийж байна. Энэ үнэлгээг хийснээр төлбөрийн системд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлон, түүнийг үнэлэх, бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломж бүрддэг. Үнэлгээний үр дүнгээс үзэхэд, 2021 оны байдлаар Банксүлжээ системд СЗЗДБ-ийн 24 зарчмаас 13 зарчим хэрэгжсэн, дөрвөн зарчим ерөнхийдөө хэрэгжсэн, нэг зарчим хэсэгчлэн хэрэгжсэн, долоон зарчим хамааралгүй байгаа бол ТБҮЦС-ийн хувьд мөн 13 зарчим бүрэн хэрэгжсэн, дөрвөн зарчим ерөнхийдөө хэрэгжсэн, долоон зарчим хамааралгүй байна.

Хүснэгт 2

Монгол Улсын төлбөрийн систем ба СЗЗДБ-ийн зарчмын хэрэгжилт

СЗЗДБ-ийн зарчмууд	Банксүлжээ систем	Төв банкны үнэт цаасны систем
Зарчим 1. Хууль эрх зүйн орчин	✓	✓
Зарчим 2. Удирдлага ба засаглал	✓	✓
Зарчим 3. Эрсдэлийн удирдлага	✓	✓
Зарчим 4. Зээлийн эрсдэл	✓	✓
Зарчим 5. Барьцаа	✓	✓
Зарчим 6. Маржин	● Хамааралгүй	
Зарчим 7. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэл	✓	✓
Зарчим 8. Төлбөрийн эцэслэлт	✓	✓
Зарчим 9. Мөнгөн хөрөнгийг шилжүүлэх төлбөр тооцоо	✓	✓
Зарчим 10. Үнэт цаасыг биет байдлаар шилжүүлэх	● Хамааралгүй	
Зарчим 11. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв	●	✓
Зарчим 12. Хөрөнгийн дүнгээр солилцох (Exchange-of-value) төлбөр тооцооны систем	✓	✓

Зарчим 13. Оролцогч үүргээ биелүүлэх боломжгүй болсон үед дагаж мөрдөх дүрэм, журам		
Зарчим 14. Харилцагчийн позиц, барьцаа хөрөнгийг тусгаарлан бүртгэх, шилжүүлэх		Хамааралгүй
Зарчим 15. Бизнесийн эрсдэл		
Зарчим 16. Хадгалалт ба хөрөнгө оруулалтын эрсдэл		
Зарчим 17. Үйл ажиллагааны эрсдэл		
Зарчим 18. Төлбөрийн системд оролцох ба тавигдах шаардлага		
Зарчим 19. Шууд бус оролцогчийн зохицуулалт		Хамааралгүй
Зарчим 20. СЗЗДБ-ийн холболт		Хамааралгүй
Зарчим 21. Үр ашигтай ба үр дүнтэй байдал		
Зарчим 22. Мэдээлэл харилцаа холбооны стандарт, горим		
Зарчим 23. Дүрэм, журам, мэдээллийн ил тод байдал		
Зарчим 24. АМС дахь мэдээллийн ил тод байдал		Хамааралгүй

СЗЗДБ-ийн зарчмуудын хэрэгжилт:

Ерөнхий бүтэц

Банксүлжээ систем: Их дүнтэй төлбөрийн системийн журам, гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн, тодорхой, ил тод удирдлага зохион байгуулалттай, холбогдох эрсдэлийг удирдах зохицуулалт, зохион байгуулалтыг тодорхой түвшинд бүрдүүлсэн. Зөрчлийн тухай хуульд Үндэсний төлбөрийн системийн тухай хууль тогтоомжийг зөрчих тохиолдолд хүлээлгэх хариуцлагын заалтыг 2020 онд оруулсан нь төлбөрийн системийн эрх зүйн орчныг сайжруулж, Монголбанкны зүгээс тавих хяналтыг бэхжүүлэх боломжтой болжээ. Монголбанкнаас төлбөрийн системийн найдвартай ажиллагаа, үр ашигтай байдлыг нэн тэргүүнд тавьж, санхүүгийн тогтвортой байдал, олон нийтийн эрх ашгийг хамгаалах бодлогын хүрээнд дүрэм, журмыг боловсруулдаг бөгөөд нэмэлт өөрчлөлт оруулах бол төлбөрийн системийн бүх оролцогчдоос санал авдаг.

ТБҮЦС: Төв банкны тухай хууль болон Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд заасны дагуу Монголбанк нь ТБҮЦ-ны ҮЦТХТ болон ҮЦТТС-ийн үүргийг гүйцэтгэж, түүний найдвартай тасралтгүй ажиллагааг хангах зорилгоор холбогдох журмыг боловсруулан гаргасан. ТБҮЦ-ны арилжааны эрсдэлийг “Монголбанкны үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын журам”-аар зохицуулдаг. Эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах ажлын хүрээнд оролцогчдын Монголбанкнаас өдрийн зээл авах үйл ажиллагааг автоматжуулахаар Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн систем

(CSD) програм хангамжийг 2022 онд нэвтрүүлэх ажлыг эхлүүлээд байна. Банксүлжээ систем болон ТБҮЦС-ийн үйл ажиллагаа нь зөвхөн Монгол Улсад явагддаг бөгөөд эрх зүйн зохицуулалтын талаарх мэдээллийг Монголбанкны цахим хуудаст тухай бүр байршуулж, олон нийтэд мэдээлдэг.

Зээлийн болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлийн удирдлага

Банксүлжээ систем: Ирээдүйд санхүүгийн үүргээ биелүүлэх боломжгүй болох үед зээлийн эрсдэл үүсэх боломжтой байдаг тул Монголбанк нь оролцогчдын эзэмшиж буй ТБҮЦ-ыг барьцаалан “Үнэт цаас буцаан худалдан авах нөхцөлтэй зарах ерөнхий гэрээ”-г байгуулдаг. Зээлийн эрсдэл гарсан үед, репо хэлцлээр хийсэн үнэт цаасыг Монголбанк бүр мөсөн шилжүүлэхийг гэрээнд заасан. Гэрээнд клирингийн системийн үр дүнгийн төлбөр тооцоог саадгүй гүйцэтгэхэд ашиглах зорилгоор барьцаа хөрөнгийг харилцах дансанд тусгаарладаг бөгөөд үр дүнгийн төлбөр тооцоог амжилттай гүйцэтгэсний дараа барьцааг чөлөөлөх, оролцогч нь тухайн хөрөнгийг төлбөр тооцоонд ашиглах эрх нээгдэнэ гэж зохицуулсан нь зээлийн эрсдэлээс хамгаалах удирдлагын оновчтой арга хэрэгсэл болж байна.

Банкууд заавал байлгах нөөцийн өдрөөр хангах хөрөнгийг Монголбанкна дахь харилцах дансандаа өдөр бүрийн гүйлгээний эцэст тус тус байршуулдаг. Мөн банк хоорондын валют арилжааны цахим талбар, валютын дуудлага худалдаа зэргийг ашиглан банкууд эзэмшиж буй валютаа төгрөгт хөрвүүлэх боломжтой.

ТБҮЦС: Төлбөр тооцоо нь ТЭН зарчмаар явагддаг тул ТБҮЦ-ны төлбөр тооцооны үйл ажиллагаанд оролцогчдод зээлийн эрсдэл үүсэхгүй. Мөнгөн хөрөнгө болон үнэт цаасны төлбөр тооцоо нь нэг бүрчлэн хийгддэг. Төв банкны тухай хуульд заасны дагуу банканд зээл олгоход барьцаалах хөрөнгийн жагсаалтанд зээлийн эрсдэл багатай, түргэн хөрвөх активыг оруулж Монголбанкны Ерөнхийлөгчийн шийдвэрээр баталдаг. Монголбанкнаас банканд олгох зээл, санхүүжилтийн барьцаа хөрөнгө, үнэт цаасны үнэ цэнийг тооцох зааврын дагуу барьцаа хөрөнгийн үнэлгээ, чанарт тогтмол хяналт тавьж байна. Мөн барьцаа хөрөнгийн зах зээлийн үнэлгээнээс эрсдэлийн хямдруулалтын хувь тооцож санхүүжилт олгодог. Үнэлгээний хорогдуулалтын хувийг тухайн активын зээлийн эрсдэл, хөрвөх чадварт үндэслэн тогтоодог. Барьцаа хөрөнгийн хорогдуулалтын хувийг жил бүр хянаж, хангалттай эсэхийг дүгнэдэг.

Өмнө дурдсанчлан Монголбанк нь ТБҮЦ-ны хувьд ҮЦТХТ болон ҮЦТТС-ийн үүргийг зэрэг гүйцэтгэж, худалдагч болон худалдан авагч банкны дансанд үнэт цаас болон бэлэн мөнгийг нэгэн зэрэг харилцан шилжүүлдэг. Энэхүү үйл ажиллагаанд төв банкны хариуцан ажиллуулж байгаа төлбөрийн систем, төв банканд байршиж буй мөнгөн хөрөнгийг ашиглаж байгаа тул төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлд орохгүй байх боломж бүрдсэн.

Төлбөр тооцоо

Банксүлжээ систем: Үндэсний төлбөрийн системийн хуулинд төлбөрийн эцэслэлт, төлбөр тооцооны барьцаа хөрөнгийн тухай тодорхой тусгасан. Тус хуулинд төлбөрийн системийн шууд оролцогч нь төлбөр тооцоог Монголбанкна дахь төлбөр тооцооны дансаар дамжуулан гүйцэтгэнэ гэж заасан. Их дүнтэй төлбөрийн системийн журамд зааснаар оролцогч нь дараалалд орсон өөрийн гүйлгээг цуцлах боломжтой ба төлбөр

тооцоо хийгдсэн гүйлгээг цуцлах боломжгүй, ажлын өдөр эхлэх бүрд оролцогчийн харилцах дансанд тодорхой дүнг барьцаа хэлбэрээр барьж болох бөгөөд энэхүү хөрөнгийг зөвхөн клирингийн системийн үр дүнгийн төлбөр тооцоог саадгүй гүйцэтгэх зорилгоор ашиглах гэж тодорхой заасан. Төлбөр тооцоог бодит цагийн горимоор дамжуулдаг.

ТБҮЦС: ТБҮЦ-ны мөнгөн хөрөнгийн шилжүүлгийг Банксүлжээ системээр хийх бөгөөд тухайн төлбөр тооцоог эцсийн гэж үзэх нөхцөлийг Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд тусгасан. Төв банкны үнэт цаасны арилжааны төлбөр тооцоог тухайн оролцогчийн Монголбанкна дахь харилцах дансаар дамжуулан бодит цагийн горимоор гүйцэтгэдэг.

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв болон Хөрөнгийн дүнгээр солилцох төлбөр тооцооны систем

Банксүлжээ систем: Үнэт цаасны болон гадаад валютын арилжааг зохицуулсан журмуудын дагуу гүйлгээг хийх бөгөөд эдгээр арилжаа нь ТЭН болон ТЭТ хийх нөхцөлийн дагуу хийгддэг тул үндсэн эрсдэлээс зайлсхийх боломжийг бүрдүүлж байна.

ТБҮЦС: Төв банкны үнэт цаасыг зөвхөн биет бус хэлбэрээр гаргах бөгөөд оролцогчийн худалдан авсан үнэт цаасыг "Монголбанкны нягтлан бодох бүртгэлийн бодлого"-ын баримт бичгийн дагуу бүртгэдэг. ТБҮЦ-ны бүртгэлийн үйл ажиллагаанд олон улсын хөндлөнгийн аудитын байгууллага жил бүр шалгалт хийдэг. "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийн дагуу оролцогчийн худалдан авсан үнэт цаасыг бүртгэлд тусгасныг батлах баримтыг тухай бүр оролцогчдоод хүргүүлж, оролцогчдын дансдын үлдэгдлийг улирал тутам хоорондоо нийлж тохируулдаг. Оролцогчид нь өөрийн эзэмшилд байгаа ТБҮЦ-ыг бодит цагийн горимд орж шалгах боломжтой байдаг. Монголбанк нь Төв банкны үнэт цаасыг төвлөрүүлэн хадгалж, хамгаалах, түүний төлбөр тооцоог хийхээс өөр үйлчилгээ үзүүлдэггүй. Монголбанк ба банкны хооронд үнэт цаасыг худалдахтай холбоотой мөнгөн хөрөнгийн болон үнэт цаасны шилжүүлгийг ТЭН зарчмаар нэгэн зэрэг хийдэг.

Үүргээ биелүүлэх боломжгүй болох үеийн удирдлага

Банксүлжээ систем: ҮТСТХ-нд оролцогч татан буугдсан тохиолдолд авах арга хэмжээний талаар тусгасан. Оролцогч үүргээ биелүүлэх боломжгүй болсноос үүссэн хохирол алдагдлыг хаах, төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангуулах талаар Их дүнтэй төлбөрийн системийн журмын "Эрсдэлийн удирдлага" хэсэгт заасан. ҮТСТХ болон Их дүнтэй төлбөрийн системийн журам нийтэд ил тод цахим хуудсанд байршиж байна.

ТБҮЦС: Оролцогч үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд Монголбанкны зүгээс санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх зохицуулалт байхгүй бөгөөд тухайн оролцогч бусад оролцогчдоос эх үүсвэр татах боломжтой. Монголбанкнаас баталсан холбогдох журамд оролцогчийг үүргээ биелүүлэх боломжгүй болох үед гэрээний үүргээ биелүүлээгүйд тооцох тохиолдол, авах арга хэмжээний талаар тусгасан. Эдгээр журмуудыг өөрийн цахим хуудсанд байршуулж, олон нийтэд мэдээлдэг. ТБҮЦ нь биржээр арилжаалагддаггүй, зах зээлийн үнэлгээг тооцох боломжгүй үнэт цаас юм.

Бизнесийн болон үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага

Банксүлжээ систем: Энэхүү системийг Монголбанк хариуцан ажиллуулдаг бөгөөд үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлыг бүрэн хариуцдаг. Банксүлжээ системээр дамжуулж буй гүйлгээ, хуваарьт цагаас хойш хийж буй гүйлгээ тутамд өөр өөр шимтгэл тогтоосон бөгөөд оролцогчоос гишүүнчлэлийн татвар авдаггүй. Монголбанк нь төлбөрийн системд учирч болзошгүй системийн эрсдэлээс сэргийлэх, түүнийг үнэлэх, удирдах, оролцогчдын төлбөрийн систем дэх эрх тэгш оролцоог хангах талаар “Төлбөрийн системийн хяналтын бодлого”-д тодорхой тусгаж, анхаарч ажиллаж байна. Мөн Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар баталсан Төлбөр тооцооны системийн онцгой байдлын үед ажиллах төлөвлөгөөг туршиж хэрэгжүүлдэг.

Монголбанк нь өөрийн болон оролцогчдынхоо хөрөнгийг Зарчим 16-д дурдсанчлан бусад хуулийн этгээдэд хадгалуулдаггүй бөгөөд үүрэг хариуцлагынхаа хүрээнд өөрийн хөрөнгийг удирдан зохион байгуулдаг. Банксүлжээ систем нь кастодиан банк ашигладаггүй.

Төлбөрийн системд мөрдөх мэдээллийн технологийн тасралтгүй, найдвартай ажиллагааны журмыг мөрддөг бөгөөд энэхүү журмын зорилго нь мэдээллийн технологийн үйл ажиллагаа доголдсоны улмаас төлбөр тооцоо саатах, системийн эрсдэл үүсэх нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэхийн тулд төлбөрийн системийн оператор, оролцогчдын үйл ажиллагаандаа дагаж мөрдвөл зохих шаардлагуудыг тодорхойлох, түүнд хяналт тавихад оршино.

ТБҮЦС: Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журамд заасны дагуу Монголбанк нь зээл, үнэт цаас болон бусад активын хугацаа чанар, эргэн төлөгдөх магадлалын үзүүлэлтийг тооцон ангилж, болзошгүй алдагдлын нөөцийн санг байгуулан ажиллаж байна.

“Монголбанкны үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын журам”-д үйл ажиллагааны эрсдэлийг тодорхойлж, түүнийг хэрхэн удирдах зарчим, үүргийн хуваарилалт, үнэлэх аргачлалыг тусгасан байна. Мөн мэргэшсэн боловсон хүчнийг олж бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар баримтлах хүний нөөцийн бодлогын баримт бичгийг батлуулжээ.

Оролцоо

Банксүлжээ систем: Үндэсний төлбөрийн системийн тухай хуулинд шаардлага, шалгууруудыг үйлчилгээ, хэрэгсэл бүрээр тодорхойлсон ба оператор, оролцогч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд, түүний албан тушаалтан үндэсний төлбөрийн системийн тухай хууль тогтоомж зөрчсөн бол тухайн зөрчлийн шинж байдлыг харгалзан Монголбанкны авах арга хэмжээг тодорхой тусгасан байна. Мөн Их дүнтэй төлбөрийн системийн журамд оролцогчдод тавигдах шалгуур үзүүлэлт болон оролцогчдын эрхийг түдгэлзүүлэх, цуцлах талаар тодорхой тусгасан байна. Бүх оролцогчдод ижил шаардлага, шалгуур тавьдаг бөгөөд шаардлага шалгуур бүхий журмыг нийтэд ил тод, Монголбанкны цахим хуудсанд байршуулжээ.

ТБҮЦС: Төв банкны үнэт цаасны арилжаатай холбоотой журамд оролцогчдод тавигдах шаардлага, шалгуурыг тусгасан бөгөөд оролцогчдыг системд шударга, нээлттэй зарчмаар нэвтэрч, үйлчилгээ авах бололцоог бүрдүүлсэн ба үйлчилгээг хүндрэлгүй үзүүлэхэд чиглэгдсэн, эрх тэгш боломжийг олгосон байна. Эдгээр журмуудыг нийтэд ил тод, Монголбанкны цахим хуудсанд байршуулсан байна. НУСЗЗГ нь оролцогчдод тавьж буй шаардлага, шалгуурын хэрэгжилтэд хяналт тавина.

Үр ашигтай байдал

Банксүлжээ систем: Банксүлжээ системийн оператор нь Монголбанк бөгөөд гол зорилго нь системийн тасралтгүй найдвартай үйл ажиллагааг хангахад чиглэгдэж байна.

ТБҮЦС: ТБҮЦ-ны системийг ажиллуулснаар үйл ажиллагааны нэмэлт зардал гардаггүй, оролцогчдоос төлбөр хураамж авдаггүй, Монголбанк нь банк хоорондын мөнгөний зах, Төв банкны нээлттэй захын үйл ажиллагаа, санхүүгийн тогтвортой, үр ашигтай байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.

Банксүлжээ болон ТБҮЦ-ны системийн холбогдох тоног төхөөрөмж, сервер, дамжуулж буй мэдээлэлд тавигдах шаардлага, горимыг мэдээлэл харилцаа холбооны олон улсын ISO20022 мессэж стандартад нийцүүлэн ажиллаж байна.

Ил тод байдал

Монголбанк төлбөрийн систем ба ТБҮЦ-ны системтэй холбоотой дүрэм, журам, бодлогыг боловсруулан гаргаж Монголбанкны цахим хуудсанд олон нийтэд нээлттэй байршуулдаг.

4.3. Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагааны зөвшөөрөл

Үндэсний төлбөрийн системийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд клирингийн системийн оператор, төлбөр тооцооны төлөөлөгч, төлбөрийн карт гаргах, хүлээн авах болон цахим мөнгөний үйл ажиллагаа эрхлэх хүсэлтэй байгууллагын тоо жил тутамд нэмэгдсээр байна. Өнгөрсөн жилүүдэд Монголбанк 40 гаруй зөвшөөрлийн хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэжээ.

Зөвшөөрлийн материал шалгах үйл явц нь хувь нийлүүлсэн хөрөнгийн гарал үүслийг тогтоох, их хэмжээний цаасан мэдээлэлтэй танилцах, програм хангамж, дэд бүтэц, түүний аюулгүй найдвартай ажиллагааг биечлэн шалгах, системийн оператороор дүгнэлт гаргуулах, хууль, журмаар тогтоосон шаардлага хангаж байгаа эсэхийг судлан дүгнэлт гаргах, дүн шигжилгээ хийх зэрэг процессын олон дамжлагатай ажиллагаа байдаг. Зөвшөөрлийн материал бүрдүүлж Монголбанканд ирүүлэхдээ шаардлага хангасан материал ирүүлээгүй тохиолдолд хянан шалгагчдын зүгээс хуульд заасан хугацаанд хамтран ажиллаж, хууль, журмын шаардлагыг хангуулах зорилгоор шаардлагатай тохиолдолд албан уулзалтыг зохион байгуулж, зөвлөмж зөвлөгөө өгөх зэргээр финтек байгууллагыг дэмжих зарчмыг баримтлан ажиллаж байна.

Монгол Улсын үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх стратеги

Институцийн тогтолцоо

Төлбөр тооцооны дэд бүтэц

Төлбөрийн хэрэгсэл ба үйлчилгээ

ТАВ. ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ

Монголбанк нь 2009 оноос эхлэн Монгол Улсын үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх дунд хугацааны стратегийг таван жил тутамд батлан, хэрэгжүүлж ирсэн билээ. Анхны стратегид төлбөрийн системийг 2009-2014 онд хөгжүүлэх зорилт, удаах стратегид 2015-2020 онд хөгжүүлэх зорилго, зорилтыг тодорхойлж байсан ажээ.

Өмнөх стратегийн баримт бичгүүдэд заасан зорилтуудыг амжилттай хэрэгжүүлснээр бэлэн бус төлбөр тооцоог дэмжих, техник, технологийн дэвшилд суурилсан төлбөрийн шинэ үйлчилгээ нэвтрүүлж, төлбөр тооцоог бодит цагийн горимоор, нэг бүрчлэн гүйцэтгэх, бэлэн бус төлбөрийн шинэ хэрэгсэл, цахим мөнгөний үйлчилгээг дэлгэрүүлж, төлбөрийн системийн талаар Төвбанкнаас баримтлах бодлого ба хяналт зохицуулалтыг бий болгосон. Хоёр дахь стратегийн хэрэгжилтийн хүрээнд төлбөрийн системийн эрх зүйн орчинг сайжруулж, Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийг мөрдөж эхэлсэн нь онцлох амжилт байлаа.

Монголбанкнаас үндэсний төлбөрийн системийг 2022-2026 онд хөгжүүлэх стратегийн баримт бичгийн төслийг бэлэн болгоод байна. Тус стратегид 2026 он гэхэд Монгол Улсад өрсөлдөөн, инновацид тулгуурласан, хүртээмжийг нэмэгдүүлж, эрсдэлийг бууруулсан найдвартай, аюулгүй ажиллагааг бүрэн хангасан дэд бүтцээр дамжуулан төлбөр тооцоог гүйцэтгэж, төлбөр тооцоог улам бүр дижитал болгох зорилтыг дэвшүүлж байна.

Шинэ стратегийн зорилт, бүтцийг дараахь үндсэн гурван чиглэлээр тодорхойлжээ. Үүнд:

1. Төлбөр тооцоо, клирингийн системийг бэхжүүлэх;
2. Дэд бүтцийн үр ашигтай, найдвартай, тасралтгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хангах;
3. Цахим төлбөрийн хэрэгсэл, дэвшилтэт үйлчилгээг өргөжүүлэх.

Эдгээр гурван чиглэл тус бүрийн хүрээнд авч хэрэгжүүлэх зорилго, түүнд чиглэсэн арга хэмжээг дараах есөн гол “тулгуур багана”-аар авч үзье.

Хууль эрх зүйн орчин

Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийг 2018 оноос эхлэн мөрдөж байгаа хэдий ч технологийн хөгжлийг даган төлбөрийн экосистем мөн л хурдацтай өөрчлөгдөж байгаа тул эрх зүйн орчинг шинэчлэх, зохицуулагч байгууллагын хамтын ажиллагаа, хяналтыг сайжруулах шаардлага гарч байна. Төлбөрийн системийн шинэ оролцогч финтек байгууллагуудын үйл ажиллагаа өргөжин инноваци эрчимтэй нэвтэрч, төлбөрийн үйлчилгээний шинэ шийдлүүдийг ашиглах шинэ боломж нэмэгдэж байгаа тул тэдгээрийг зөв зохистой удирдаж, үүсч болзошгүй эрсдэлээс сэргийлэхийн тулд хууль тогтоомжийг эргэн харах нь зүйтэй байна.

Түүнчлэн одоогийн мөрдөж байгаа “Үндэсний төлбөрийн системийн тухай” хууль болон 2002 онд батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай” хууль нь банк бус төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн тусгай зөвшөөрлийн асуудлаар хоорондоо зөрчилтэй зохицуулалт байсаар байгаа тул энэхүү зөрчилтэй байдлыг арилгах шаардлага тулгарч

байна. Иймд Үндэсний төлбөрийн системийн тухай хууль болон бусад холбогдох хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, улмаар шинэчилсэн хуулийн дагуу шаардлагатай журам, зааврыг боловсруулан хэрэгжүүлэх замаар төлбөрийн системийн эрх зүйн орчныг сайжруулахыг зорьж байна.

Хяналт зохицуулалт

Технологийн өөрчлөлтийг дагаж санхүүгийн зах зээлд төлбөрийн үйлчилгээ үзүүлэх шинэ оролцогчид бий болсон нь төлбөрийн системийн хяналт зохицуулалтыг нарийн төвөгтэй болгож байгаа тул төлбөрийн системд хяналт тавих Төв банкны эрх үүрэг, хамрах хүрээг өргөжүүлэх нь зүйтэй юм. Цаашид ч инноваци хурдацтай хөгжих төлөвтэй байгаа тул Төв банк төлбөрийн үйлчилгээний шинэ нөхцөл байдалд хариу хурдан үзүүлэх, түүнийг зөв зохистой удирдан чиглүүлэх, учирч болзошгүй эрсдэлийг үнэн зөв үнэлэх, хяналтын бодлого, үйл ажиллагааг шинэчлэх зайлшгүй шаардлага тулгарч байна. Мөн хяналт шалгалтын ажилтнуудын нөөцийг нэмэгдүүлэх, ур чадварыг сайжруулах, төлбөрийн шинэ хэрэгсэл, үйлчилгээ, схем болон системийн талаарх мэдлэг, мэдээллийг дээшлүүлэхэд чиглэсэн чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Монголбанк нь бага дүнтэй төлбөрийн систем, төлбөрийн шинэ хэрэгсэл ба үйлчилгээ нь олон улсад нийтлэг мөрдөж буй стандартад нийцэж буй талаарх үнэлгээг тогтмол хийж хэвшүүлэх шинэ зорилтыг дэвшүүлсэн.

Хамтын ажиллагаа

Үндэсний төлбөрийн системийг оновчтой, үр ашигтай байдлаар хөгжүүлэхэд нэг талаас зохицуулагч ба системийн оролцогчид, нөгөө талаас зохицуулагч байгууллагын хамтын ажиллагаа зайлшгүй шаардлагатай байдаг. Монгол Улсын хувьд хамтын ажиллагааны үндсэн форум нь Үндэсний төлбөрийн системийн зөвлөл бөгөөд зорилтот хугацаанд буюу 2022-2026 онуудад зөвлөлийн үйл ажиллагааг шинэ түвшинд гаргаж, төлбөрийн системийн нийгэм-эдийн засагт үзүүлэх нөлөө бүхий асуудал, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгоход чиглэсэн бодлого, удирдамж, зөвлөмжийн талаар зөвлөлийн гишүүдийн туршлага, мэдлэгийг дайчлах боломжийг нэмэгдүүлэхийг зорьж байна.

Түүнчлэн Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Харилцаа холбооны зохицуулах хорооны хамтарсан Харилцан ойлголцлын санамж бичигт үнэт цаасны төлбөр тооцооны системийн талаар талуудын хүлээх эрх үүрэг, харилцан солилцох мэдээллийг тодорхой тусгаж, хяналтын тогтолцоог бэхжүүлэх нь зүйтэй юм.

Их ба бага дүнтэй төлбөрийн систем

Эдийн засаг, санхүүгийн салбарын төлбөр тооцоо нь төлбөрийн системийн найдвартай, тасралтгүй ажиллагаанаас шууд хамааралтай тул аливаа тасалдал, саатал нь санхүүгийн бүх системд хурдан тархаж, их хэмжээний хохирол учруулах нөхцөл байдал үүсгэж, санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй. Монголбанкнаас их болон бага дүнтэй төлбөрийн системүүдийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах, кибер халдлагаас сэргийлж аюулгүй байдлыг хангах нь нэн тэргүүний зорилт гэж үзэж байна. Түүнчлэн Төв банкнаас зөвшөөрсөн барьцаа хөрөнгө бүхий оролцогчид өдрийн зээл олгох үйл ажиллагааг бүрэн автоматжуулахад анхаарах нь зүйтэй. Монголбанк

төлбөрийн систем дэх кибер аюулгүй байдлын олон улсын стандартыг нэвтрүүлэх, мөн их, бага болон картын төлбөрийн системийн хэрэглэгчийн хооронд мэдлэг, мэдээлэл, санал солилцох группийг үүсгэн ажиллуулахаар төлөвлөж байна.

Банк хоорондын мөнгөний зах зээл ба валютын арилжааны төлбөр тооцоо

Монголбанкнаас мөнгөний зах зээл, гадаад валютын арилжаа, ҮЦТТС ба ҮЦТХТ-ийн аюулгүй найдвартай ажиллагаа, олон талт төлбөр тооцоог Банксүлжээ системтэй нэгтгэх зорилгоор арилжааны платформыг нэвтрүүлэхийг зорьж байна.

Монголбанкны системээс гадуурх валютын захын үйл ажиллагаанд шинжилгээ хийж, дотоодын зах зээл дэх гадаад валютын төлбөр болон хил дамнасан төлбөр тооцооны урсгалыг анхаарч үзнэ. Үнэт цаасны клиринг, валютын захын төлбөр тооцооны чиглэлээр СЗХ-той нягт хамтран ажиллах нь зүйтэй юм.

Төлбөрийн хэрэгсэл ба төлбөрийн үйлчилгээ

Технологийн шинэчлэл нь төлбөрийн шинэ хэрэгсэл ба үйлчилгээг нэвтрүүлэх, төлбөрийн системд шинэ оролцогч гарч ирэх, улмаар төлбөрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах боломжийг бий болгож байна. Монгол Улсын хувьд нийт хүн амын 93 хувь нь санхүүгийн байгууллагад данстай ба бага дүнтэй төлбөр тооцооны дэд бүтэц, үйлчилгээний найдвартай байдалд анхаарч, байнга шинэчлэн сайжруулж ирсэн тул бэлэн мөнгөний хэрэглээ жил бүр буурч, цахим төлбөр тооцоо нэмэгдсээр байна. Энэхүү гайхалтай үр дүнд тулгуурлан Монголбанкны зүгээс төлбөрийн цахим хэрэгслийн ашиглалтыг сайжруулах, инновацийг дэмжих бодлого баримталж байна.

Төлбөрийн карт нь бэлэн бус төлбөр тооцоонд хамгийн түгээмэл хэрэглэгддэг бөгөөд картын тоо 2021 онд өмнөх оноос 10.6 хувиар нэмэгдсэн байна. Мөн мобайл, интернет банкаар хийсэн картын гүйлгээ 2019 онд нийт картын гүйлгээний 32.2 хувийг эзэлж байсан бол 2020 онд 80 хувь болж өссөн байна. Картын нууцлал аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор үндэсний төлбөрийн ₮ картыг олон улсын EMV чипийн стандартад шилжих ажлыг эхлүүлээд байгаа бөгөөд 2024 онд бүрэн шилжиж дуусахаар төлөвлөж байна.

Монголбанкны зүгээс Олон улсын банкны дансны дугаарлалтыг (IBAN) нэвтрүүлж, стандартчлах ажлыг санаачлан эхлүүлээд байгаа ба 2024 он гэхэд бүтэн шилжих зорилт тавин ажиллаж байна. Түүнчлэн Монголд QR код ашиглан төлбөр тооцоог хийж гүйцэтгэх нь нэмэгдэж байгаа тул гүйлгээний тоо 2020 онд өмнөх оноос 8 дахин өсч 21.3 сая ширхэг болжээ. Иймд QR кодын нэгдсэн стандартыг тогтоож хэрэгжүүлнэ.

Зах зээлийн хөгжлийн дагуу финтек компаниуд ч төлбөрийн шинэ шийдлийг санал болгож байна. Тухайлбал, хэрэглэгчид цахим түрийвч олгох, P2P төлбөр хийх, хиймэл оюун ухаанд суурилан бичил болон жижиг зээлийн зээлжих чадварыг үнэлж зээл олгох зэрэг үйлчилгээг хэрэгжүүлж эхлээд байна. Үүний дагуу Монголбанк нь зах зээлд оролцогчидтой хамтран хэрэглэгч, олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэхэд анхаарч холбогдох арга хэмжээг авч ажиллахыг зорьж байна.

Хил дамнасан төлбөр тооцоо

Хил дамнасан мөнгөн гуйвуулгын хэмжээ жил тутам нэмэгдэж байгаа бөгөөд 2020 онд 549 сая ам.долларт хүрч 2017 оноос 2 дахин өссөн байна. Гэвч мөнгөн гуйвуулга хийхэд төлөх шимтгэл өндөр байдаг бөгөөд үүнд гуйвуулгын үйлчилгээ үзүүлэгч нь төлбөрийн системийн дэд бүтцэд нэвтрэх боломжгүй, онцгой эрхийн гэрээний дагуу банкаар дамжуулж байгаа зэрэг нь нөлөөлж байна. Мөнгөн гуйвуулгын өртгийн дэлхийн дунджийг 5 хувь хүртэл бууруулах, улмаар 2030 онд гэхэд 3 хувьд хүргэн бууруулахыг НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтод тусгажээ.

Иймд Монголбанк мөнгөн гуйвуулгын үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд банк бус мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэгчийг үндэсний төлбөрийн системийн дэд бүтцэд нэвтрэх нөхцөлийг бүрдүүлэх, мөнгөн гуйвуулгын онцгой эрхийг хязгаарлах, мөнгөн гуйвуулгын өртөг, зардал, урсгалын талаар судалгаа, шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлэхийг зорьж байна.

Засгийн газрын төлбөр тооцоо

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “E-Mongolia” цахим платформоор иргэд төрийн 181 үйлчилгээг нэг системээс авах нөхцөл бүрдэнэ. Монголбанк энэхүү Цахим Монгол төслийг дэмжиж, Засгийн газраас иргэдэд олгож буй төлбөр, мөн иргэдээс төлөх төлбөрийг үндэсний төлбөрийн системээр тасралтгүй, үр ашигтай, найдвартай байдлаар гүйцэтгэх, аюулгүй ажиллагааг хангах нөхцлийг бүрдүүлнэ. Түүнчлэн, цахим хэлбэрээр хийсэн худалдан авалтын татварын буцаан олголтыг автоматжуулахад Засгийн газартай хамтран ажиллана.